

HOM

I БӨЛӨГ

УЧИР ШАЛТГААН

I

ДӨРВӨН ҮНЭН

1. Энэхүү хүний ертөнц зовлон зүдүүрээр дүүрэн. Амьдрах нь зовлон, өглөх нь зовлон, өвдөх нь зовлон, үхэх нь зовлон. Дургүй хүргэх хүнтэй учрах нь зовлон, хайртай хүнээсээ хагацах нь зовлон. Хүссэндээ хүрэхгүй бол мөн адил зовлон. Аливаа юманд дасах нь зовлон. Энэ бол зовлонгийн үнэн юм.

Ахуй орчлонгийн зовлон зүдүүр, хүний санаа сэтгэлд цөмрөн ордог тачаал шуналаас үүддэг нь эргэлзээгүй. Ертөнцийн тачаалын үндэс шунал нь асар хүчтэй хүслэнгээс ургана. Энэхүү шунал амьдралд учиргүй дассанаас үүднэ. Нүд харж, чих сонсож буй бүхнийг хүн хүсч эхэлдэг. Тэр ч бүү хэл, үхэхийг ч хүсэх нь буй. Энэ бол зовлонгийн учир шалтгааны үнэн юм.

Хэрэв ертөнцийн тачаал шуналын бүх үндэс язгуурыг устгаж, дасаж дадсанаасаа салж ангижирвал зовлон арилна. Энэ бол зовлонг дарж устгахын үнэн мөн.

Зовлонгоос салахын тулд найман зөв зам мөрийг хөөх хэрэгтэй. Эдгээр нь зөв үзэл, зөв бодол, Зөв үг,

зөв үйл, зөв амьдрах, зөв тэмүүлэх, зөв санаж дурсах, ухаан санаагаа зөв төвлөрүүлэх болой. Энэхүү цангааг тайлагч найман мөрийг зөв замын үнэн хэмээнэ.

Энэ ертөнц зовлонгоор дүүрэн тул эдгээр үнэнийг гүн гүнзгий ухаарваас зохино. Зовлон зүдүүрээс хагацахын тулд хорвоогийн тачаал шуналаас салах хэрэгтэй. Шунал тачаалаас ангид байдалд зөвхөн гэгээрснээр хүрч болно. Гэхдээ энэхүү наймтын замыг л дагавал гэгээрнэ.

2. Номыг дагасан хүн энэхүү дөрвөн ариун үнэнийг ухаарах ёстой. Эдгээрийг ухаараагүй нь харанхуйд удтал төөрнө. Эдгээр ариун үнэнийг ухаарсан хүнийг гэгээрсэн гэж дуудна.

Бурхан багшийн сургаалыг дагахыг хүссэн хэн бүхэн хүч чадлаа шавхан энэ дөрвөн ариун үнэнийг зөв ухаарваас зохино. Ямар ч цаг үед аливаа ариун явдалтан үнэхээр ариун сэтгэл юутай бол эдгээр үнэнийг ухаарч, бусдад номлоно.

Хүн эдгээр дөрвөн ариун үнэнийг ухаармагц анх удаа хүсэл шуналаас ангижирч, хүмүүстэй маргалдахаа больж, бусдын амь насанд халдах, хулгай хийх, буруугаар хурьцах, хуурч мэхлэх, харааж загнах, бялдуучлах, атаархах, уурлаж

Учир Шалтгаан

Уцаарлахыг орхиж, оршихын мөнх бусыг ямагт санаж, зөв замаас хазайж хэлтийхгүй болно.

3. Номыг дагавал харанхуй өрөөнд бамбар асааж орсон хүнтэй адил буюу. Түнэр харанхуй сарнин замхарч эргэн тойрон гэрэл гэгээ түгнэ.

Хэрэв Номыг дагаж буй хүн дээрх дөрвөн үнэнийг ухаарвал, мунхагийн харанхуйг арилгагч оюун ухааны зулыг олно.

Бурхан багш зөвхөн энэ дөрвөн үнэнийг зааж, хүмүүсийг зааж сургадаг. Түүний сургаалыг зөв хүлээн авсан хүн эдгээр үнэний ачаар энэхүү мөнх бус ертөнцөд гэгээрч, өөрөө бусад хүмүүсийг хамгаалж, тэдний түшиг тулгуур болно.

Учир нь эдгээр үнэнийг ухаарснаар ертөнцийн шунал тачаалын эх булаг болсон харанхуй мунхгийг арилгана.

Эдгээр дөрвөн үнэнийг ачаар Бурхан багшийн шавь нар бүх ном сургаалыг эзэмшиж, ертөнцийн бүх үнэнийг ухаарагч оюун ухаан болон бодь чанаруудыг олно. Тэд, Бурхан багшийн сургаалыг хэнд ч чөлөөтэй зааж номлодог болно.

II ГАЙХАМШИГТ ХЭЛХЭЭ ХОЛБОО

1. Хүмүүсийн зовлон зүдүүрт өөрийн учир шалтгаан буйн адил, зөв замыг дагаваас гэгээрэх нь лавтайн адил, энэ хорвоогийн юмс нөхцөл байдал бүрэлдэхийн үр дагавар юм. Нөхцөл бүрэлдэхэд энэ орчлонд бүх юм буй болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм арилна.

Бороо орох, салхи үлээх, цэцэг навч дэлгэрэх, навч унах энэ бүхэн нөхцөл бүрэлдэхэд л болж буй. Хүн эцэг эхийн хоорондын холбооноос мэндэлдэг. Хоол хүнс түүний биеийг тэнхрүүлж, мэдлэг туршлага санаа сэтгэлийг нь хөгжүүлдэг.

Тиймээс бие, сэтгэл хоёр нь нөхцөл бүрэлдсэний ачаар оршин тогтнож, нөхцөл бүрэлдэхэд өөрчлөгдөнө.

Утсыг хооронд нь хэлхэхэд тор буй болохтой адил энэ ертөнцийн бүх юм өвөр зуураа хэлхээ холбоотой.

Торны нэг зангилаа дангаараа оршин тогтнож чадна гэж бодсон хүн ихээхэн алдаж буй хэрэг.

Торны зангилаа бусадтайгаа холбогдож, сая тор болно. Зангилаа бүхэн бусад зангилааны нэг хэсэг юм.

Учир Шалтгаан

2. Нөхцөл бүрэлдэж цаг нь ирэхэд цэцэг цэцэглэдэг, нөхцөл бүрэлдэхэд унаж хатадаг. Өөрсдийн дураар цэцэглэж, дураараа унаж хатах нь үгүй.

Цэцэг навч цаг нь болж нөхцөл бүрэлдэхэд цэцэглэж, мөн нөхцөл бүрэлдэхэд унаж хатах учир энэ ертөнцөд тогтонги зүйл байхгүй. Энэ дэлхийд юм бүхэн хувирч өөрчлөгдөнө. Юунаас ч үл шалтгаалан, үл өөрчлөгдөх зүйл гэж хорвоод үгүй.

Цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм төрж, цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд унаж хатах нь хөдөлшгүй үнэн юм. Бүх юм өөрчлөгдөн хувирч, байснаараа эс байх нь энэ ертөнцийн цорын ганц хувиршгүй үнэн юм. Гагцхүү энэ үнэн хэзээ ч үл өөрчлөгдөнө.

III

ХАРИЛЦАА ХОЛБОО

1. Хүний санаа бодлын зовнил, уйтгар гуниг, зовлон зүдүүр сэтгэлийн хөдөлгөөнд оршино.

Хүн нь эд баялаг, алдар гавьяа, нэр төр, тав тух, зугаа цэнгэлд дадаж, өөрөө өөртөө ч бас дассан байдаг. Үүнээс болж зовлон зүдүүр тасардаггүй.

Энэ ертөнцөд хэзээний аюул сүйрэл оршиж байдаг. Хүн аюул сүйрлээс гадна өглөх, өвдөх, үхэхээс ч зайлж чадахгүй учир зовлон зүдүүр, уйтгар гунигт автдаг билээ.

Дадаж дасах амархан учраас зовлон зүдүүр, уйтгар гуниг буй болдог. Хэрэв дадаж дасах нь алга болвол зовлон зүдүүр, уйтгар гуниг мөн ул мөргүй алга болно.

Хүний дасаж дадах сэтгэлийн уг язгуурт нь мунхаг хийгээд хомхой сэтгэлийн харанхуй ноёлож байдаг.

Мунхагийн харанхуй хэмээх нь хүмүүс энэ ертөнцөд бүх юм хувирч өөрчлөгдөхийг эс ухааран, юмс үзэгдлийн учир шалтгааны нарийн холбоог олж хараагүйг хэлнэ. Ховдог хомхой сэтгэл хэмээх нь олдохгүй юмыг хүсэх, энэ хүслээсээ үл татгалзах хүмүүсийн чанар юм.

Эд юмсын хооронд өчүүхэн бээр ялгал үгүй, гэвч хүмүүс тэдгээрийг ялгаж салгадаг. Үүний шалтгаан нь мунхаг хийгээд шунахай сэтгэлд оршино. Сайн, муу юмс гэж үгүй атал хүмүүс юмсыг сайн, муу хэмээн хуваадаг. Энэ нь мунхаг хийгээд хомхой сэтгэлээс үүднэ.

Учир Шалтгаан

Муу санаа бодол хүмүүсийн сэтгэлд байнга үүсч, тэд мунхаг учир юмсын мөн чанарыг олж харалгүй өөрөө өөртөө дасаж буруу үйл хийдэг. Тиймээс ч төөрөлддөг юм.

Хүмүүс өөрийн үйлийн цэцэрлэгт санаа сэтгэлийнхээ үрийг цацаж, мунхаг харанхуйн хөрсөөр хучиж, ховдог хомхой сэтгэлийн бороогоор чийглэж, амиа хичээх сэтгэлийн усаар усалж, буруу ташаа үзэл бодлын ургацыг ургуулж, чингээд төөрөлддөг юм.

2. Учир иймд, хүний сэтгэл нь уйтгар гуниг, зовлон зүдүүр, түгшүүр хямрал бүхий төөрөгдлийн ертөнцийг өөрөө буй болгодог.

Төөрөгдлийн ертөнц нь санаа сэтгэлийн буй болгосон төсөөлөл, таамаглалын хий орчлон юм. Гэгээрлийн ертөнцийг ч мөн адил санаа сэтгэл буй болгоно.

3. Энэ ертөнцөд гурван буруу үзэл бодол байдаг. Тэдгээрийг баримталваас хорвоогийн бүх юмыг үгүйсгэнэ. Нэгдүгээр үзэл санааг үлгэрлэвэл, хүмүүс энэ дэлхийд өөрсөдтэй нь тохиолдож буй аливаа хэрэг явдлыг заяа төөргийн дагуу болж буй гэж нотолно. Хоёрдугаар үзэл санаа нь хүмүүс энэ бүхэн бурханаас л шалтгаалсан гэдэг. Гуравдугаар үзэл

Учир Шалтгаан

санаа нь хүмүүс энэ дэлхийд болж буй аливаа үйл хэрэг учир шалтгааны ямар ч холбоогүй гэж ярьдаг.

Хэрэв бүх юмыг хувь тавиланд даатгавал энэ ертөнцийн сайн муу бүх явдал хувь тавилан л болно. Зол жаргал, золгүй явдал ч ялгаагүй, нөгөө л хувь тавилан болж, энэ хорвоод хувь тавилангаас өөр юу ч эс үлдэнэ.

Улмаар хүмүүс өөдөлж сайжрахад найдахаа больж, хөдөлмөрлөхийг орхиж, дэлхийд дэвшил хөгжил үгүй болно.

Энэ ертөнцөд бурхан ганцаараа бүхнийг хийдэг хэмээх удаах үзэл, юмсын хооронд учир шалтгааны холбоо үгүй хэмээх дараагийн үзэл аль алиных нь тухайд мөн адил няцааж болно. Хэрэв хүмүүс эдгээр үзлийг дагавал мууг үйлдэхээс татгалзах, сайныг үйлдэхийг эрмэлзэхээ болино. Учир иймээс тэгэхийн тулд хүч чадлаа дайчлах утга алдагдана.

Эл учир энэ гурван үзэл гурвуулаа буруу юм. Цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм буй болж, цаг нь болж нөхцөл бүрэлдэхэд бүх юм мөхөж сөнөнө.

II БӨЛӨГ

СЭТГЭЛ САНАА БОЛОН ЭД ЮМСЫН ҮНЭН БАЙДАЛ

I

ЮМ БҮХЭН ХУВИРЧ ӨӨРЧЛӨГДӨХ ТУЛ БАЙНГЫН МӨН ЧАНАРГҮЙ

1. Цаг болж, нөхцөл бүрэлдсэний улмаас санаа сэтгэл, махбодийн аль аль нь үүсэх учир бие нь өөрийн мөн чанаргүй билээ. Бие бээр нөхцөл нь бүрэлдэхэд буй болсон тул мөнхийн чанартай бус юм.

Хэрэв бие махбод өөрийн мөн чанартай байсан бол өөрөө ямар байхыг хүснэ, яг тийм болж чадна.

Эзэн хаан, хаант улсдаа хүссэн бүхнээ хийж чадна. Тэрбээр хүссэн цагтаа залхааж, эсвэл шагнана. Гэвч тэрбээр өөрийн махан биеийг эзэгнэн захирч чаддаггүй. Хэдийгээр эс хүссэн ч бие нь өвдөж зовооно. Хэдийгээр эс хүссэн ч бие нь өтөлж өвгөрнө.

Үүнтэй нэгэн адил санаа сэтгэл өөрийн мөн чанаргүй. Цаг нь ирж, нөхцөл бүрэлдэхэд, санаа сэтгэл буй болох тул хувирамтгай чанартай.

Хэрэв санаа сэтгэл мөн чанартай бол хүссэнээ хийж, хүсээгүйгээ үл хийхсэн. Гэтэл үнэн хэрэгтээ өөрөө эс хүссэн ч атгаг муу санаа бодлыг төрүүлж,

хэдийгээр үл хүссэн ч буянаас холдоно.

2. Бие махбод байнга орших чанартай юу, эсвэл үргэлж хувирах чанартай юу хэмээвээс хэн ч гэсэн үргэлж хувирдаг гэж хариулах нь дамжиггүй.

Хувирамтгай чанар зовлон зүдүүр үү, эсвэл баяр баясгалан уу хэмээвээс, энэ хорвоод төрсөн л бол заавал өтөлж, өвдөж, үхдэг гэдгийг ухаарсан хэн бүхэн зовлон зүдүүр гэж л хариулах болов уу.

Тийм болохоор эдгээр байнгын бус цаг хугацаа улирахад хувиран өөрчлөгдөх юм зовлон зүдүүр мөн бөгөөд тэдгээр нь мөн чанартай хэмээн үзэх нь алдаа юм.

Санаа сэтгэл ч гэсэн хувирамтгай билээ. Санаа сэтгэл бол зовлон зүдүүр бөгөөд өөрийн мөн чанаргүй юм.

Тийм учраас бидний бие махбод болон санаа сэтгэлийг тойрч буй юм бүхэн "Би", "Миний" хэмээх ухагдахуунтай өчүүхэн бээр ч холбоогүй юм.

Гагцхүү мунхаг сэтгэл энэ бүхнийг "Өөрийн" хэмээн тооцож, хагацахгүйг бодно.

Цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бие болон түүнийг

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

хүрээлэгч бүхэн буй болдог учраас тэр нь хувирч өөрчлөгдөн, хэзээ ч байнга, тогтонги байдаггүй.

Санаа сэтгэл урсаж буй ус, дүрэлзэж буй дөл лүгээ адил үргэлж хувирч өөрчлөгдөнө. Тэрбээр байрандаа тогтож эс чадах сармагчин лугаа адил байнгын хөдөлгөөн дунд оршдог билээ. Тэрбээр өчүүхэн төдий ч амар тайван байж үл чадна.

Ухаант хүн үүнийг таньж мэдээд бие махбод, санаа сэтгэлдээ дасаж дадахаас татгалзах хэрэгтэй. Аливаа хүн бие, сэтгэлдээ дасаж баригдахаа боливол гэгээрнэ.

3. Энэ ертөнцөд хэн ч өөрчилж үл чадах таван зүйл буй. Үүнд: нэгдүгээрт, өглөх хууль байхад үл өглөх, хоёрдугаарт, өвдөх жам байхад үл өвдөх, гуравдугаарт, үхэх жам байхад үл үхэх, дөрөвдүгээрт, эвдэрч өмхрөх жам байхад үл мөхөх, тавдугаарт, шавхагдаж дуусах жам байхад үл шавхагдах эдгээр болно.

Энгийн хүмүүс эдгээр зайлшгүй жамтай тулгармагцаа зовж шаналж эхэлдэг. Харин Бурхан багшийн сургаалыг ухаарсан хүн тохиолдох ёстой жамаас зайлах аргагүйг мэдэж иймэрхүү тэнэг зовлон зүдүүрээс чөлөөтэй байдаг.

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

Энэ ертөнцөд өөр дөрвөн үнэн буй. Нэгдүгээрт, амьд бүхэн мунхагийн харанхуйгаас төрж буй болдог. Хоёрдугаарт, хүссэн бүхэн хувирамтгай чанартай тул зовлон зүдүүр авчирч, үргэлж өөрчлөгдөн хувирна. Гуравдугаарт, оршиж буй юм бүхэн байнгын чанаргүй, бүгд зовлон зүдүүр мөн бөгөөд үргэлж хувирч өөрчлөгдөж байдаг. Дөрөвдүгээрт, "Би" бээр, "Миний" бээр аль аль нь үгүй.

Бүх юм хувирч өөрчлөгдөнө, аливаа юм өөрийн "БИ"- гүй гэдэг нь энэ ертөнцөд Бурхан багш мэндэлсэн эсэхээс үл шалтгаалах хөдөлшгүй үнэн мөн. Бурхан багш энэ үнэнийг танин ухаарч, хүмүүст түүнийг номлож эхэлсэн байна .

II СЭТГЭЛ САНАА

1. Төөрөгдөх, гэгээрэхийн аль аль нь санаа сэтгэлээс ургаж, аливаа юм санаа сэтгэлийн үйлдлээс үүднэ. Ид шид бүхий илбэчний ханцуйнаас янз янзын юм гарч ирэхтэй адил санаа сэтгэлээс бүх юм урган гарна.

Санаа сэтгэл хувирч хөдлөх нь эцэс төгсгөлгүй, нөөц бололцоо нь зах хязгааргүй. Тухайлбал, бузартсан сэтгэл эргэн тойрондоо бузартсан ертөнцийг бий болгож, ариун сэтгэл ариун ертөнцийг бий болгоно.

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

Гадаад ертөнц санаа сэтгэлээс шалтгаалан зүйл бүрээр хувиран өөрчлөгдөж болно.

Зураач хүн зураг бүтээдэг шиг санаа сэтгэл гадаад ертөнцийг бүтээдэг. Бурхан багшийн буй болгосон ертөнц ариухан бөгөөд элдэв шунал тачаалаас чөлөөтэй буюу. Харин хүний буй болгосон ертөнц бузартсан байх агаад шунал тачаалаар дүүрэн бүлгээ.

Сайн зураач лугаа адил санаа сэтгэл янз бүрийн ертөнцийг бүтээдэг. Энэ ертөнцөд санаа сэтгэлийн буй болгож чадахгүй тийм юм үгүй. Бурхан багш ч гэсэн мөн адил ийм чадвартай. Тиймээс ч хорвоо ертөнцийг бүтээхийн тухайд бол санаа сэтгэл, Бурхан багш, хүмүүсийн хооронд өчүүхэн бээр ялгал үгүй.

Бурхан багш, энэ ертөнцөд санаа сэтгэл, юм бүхнийг буй болгосныг зөв ухаардаг. Үүнийг зөв ойлгосон хүн жинхэнэ Бурхан багшийг олж харна.

2. Гэвч санаа сэтгэл цаг үргэлж айн эмээж, гунин гашуудаж, догдолж байдаг. Болоод өнгөрснөөс айна, болох гэж байгаагаас айна. Учир нь санаа сэтгэлд мунхагийн харанхуй, ертөнцөд дасал дадал болсон сэтгэлийн хүлээс оршино.

Чухамхүү ийм мунхаг болоод шунахай санаа сэтгэлээс төөрөгдлийн ертөнц үүднэ. Ертөнцийн төөрөгдлийн бүхий л учир шалтгаан эцсийн эцэст санаа сэтгэлд л оршино.

Төрөх, үхэхийн аль нь ч санаа сэтгэлээс үүдэх тул амьдрал, үхлийн тухай буруу ташаа төсөөлөл буй болгодог санаа сэтгэл мөхвөл түүнтэй хамт буруу ташаа төсөөлөл ч замхарна.

Төөрөгдлийн ертөнц санаа сэтгэлээс ургана. Төөрөлдсөн сэтгэлийн нүдээр орчлонг харах учир энэ хорвоо төөрөгдөл, буруу ташаа ойлголтоор дүүрэн байдаг. Төөрөгдлийн ертөнц санаа сэтгэлээс эс хамааран бие дааж тогтнож чадахгүйг ухаарвал бузраас салж, гэгээрнэ. Улмаар санаа сэтгэл энэ ертөнцийг удирдаж, дагуулан чиглүүлнэ. Хэрэв санаа сэтгэл төөрөлдөж байвал хорвоо ертөнц адилхан төөрөлддөг.

3. Ертөнцийн юм бүхнийг санаа сэтгэл буй болгож, удирдана. Ертөнцийн бүх юм санаа сэтгэл л юм. Муу юм хэлдэг, хийдэг, сэтгэл нь бузартсан хүнийг зовлон зүдүүр салахгүй дагаж байдгийг зүйрлэвэл шар үхрийн араас үхэр тэрэг үргэлж дагахтай адил бүлгээ.

Хүн сайн санаа өвөрлөж, сайныг үйлдэж, хэлж

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

явбал түүнийг баяр баясгалан дагах бөгөөд үлгэрлэвээс сүүдэр нь эзнээ дагахтай адил юм. Энэ ертөнцөд муу үйл хийж буй хүн түүнээсээ болон зовж зүдэрч, хойд төрөлдөө шийтгэл хүлээж, бүр ч их тарчилж зовно.

Сайныг үйлдэж буй хүн энэ ертөнцөд түүнийхээ ачаар баярлан баясч, хойд төрөлдөө үр шимий нь хүртэж улам их цэнгэж жаргана.

Санаа сэтгэл будагнавал, зам мөр тэгш хийгээд дардан бус болж хүмүүс бүдчин бүдэрнэ. Санаа сэтгэл ариун байвал зам мөр үргэлж тэгш дардан байна.

Ариун тунгалаг бие, сэтгэлтэй хүн шулмын тавьсан хавх зангууг тас татаж, Бурхан багшийн оронд очно. Сэтгэл санаа тайван хүн амар амгаланг олж, өдөр, шөнөгүй санаа сэтгэлээ төгс төгөлдөр болгодог.

III

ЭД ЮМСЫН ҮНЭН БАЙДАЛ

1. Энэ ертөнцөд юм бүхэн цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүтэх учир эд юмсын хооронд өчүүхэн бээр ялгал үгүй. Гэвч хүмүүс тэдгээрийг хоорондоо ялгаатай хэмээнэ. Үүнд тэдний ухвар мөчид бодол санаа оршино.

Тэнгэрт баруун хязгаар, зүүн хязгаар аль нь ч байхгүй бүлгээ. Гэвч хүмүүс түүнийг баруун, зүүн хэмээн хувааж тийм байх ёстой юм шиг бодно.

Тоо нэгээс эхлэн хязгааргүйд хүрдэг. Эдгээр нь цөм бүхэл тоонууд юм. Тоонд ялгаа үгүй, их тоо, бага тоо гэж байхгүй. Харин хүмүүс л өөрсдийн амрыг бодож ялгаж, салгаж байхын тулд тоог их, бага хэмээн хувааж ангилдаг.

Ер нь амьдрах, үхэх үйл явцын аль нь ч байхгүй бүлгээ. Гэвч хүмүүс өөрсдөө амьдрах, үхэхийг ялган үздэг. Үүнтэй адил аливаа үйл хэргийг сайн гэж хэлж болохгүй, муу ч гэж хэлж болохгүй. Гэвч хүмүүс үйл хэргийг сайн, муу хэмээн ялгана. Энэ бол хүний ухвар мөчид бодол.

Бурхан багш юмс хоорондоо ялгаатай гэж үздэггүй. Тэрбээр энэ ертөнцийг тэнгэрт хөвж буй үүл, зүүд зэрэглээ мэтээр үзэж, санаа сэтгэлийн хүсч буй, үл хүсч буй юм бүхэн хоосон буюу мөн чанаргүй болохыг сайн мэддэг билээ. Тэрбээр санаа сэтгэлийн аливаа хүсэл шуналаас чөлөөтэй юм.

2. Санаа сэтгэл тав тухтай, сайн сайхан амьдрахыг хүсэх тул хүмүүс хорвоогийн бүх юманд дасаж дотно болдог. Тэд эд баялаг, өмч хөрөнгө, алдар гавьяа, амьдрал юунд дасаж дотносдог.

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

Хүмүүс байгаа хийгээд байхгүй юманд, буян, нүгэл, зөв, буруу, ер бүх юманд дасдаг учраас төөрөлдөн зовж зүдэрдэг.

Эрт урьд цагт нэг хүн амьдарч байжээ. Нэгэнтээ тэрбээр холын аянд гарч том гол мөрөнд тулж иржээ. Тэрбээр бодсон нь: "Энэ талын эрэг дээр аюултай, цаад талын эрэг дээр аюулгүй юм байна". Тэрбээр сал хийж мөрнийг эсэн мэнд гаталж, цаад талын эрэг дээр гарчээ. Аюулгүй эрэгт гарсныхаа дараа тэрбээр эрэгцүүлсэн нь: "Энэ сал намайг эрэг дээр эсэн мэнд гаргаж их тус боллоо. Тиймээс би энэ салыг хаялгүй цааш үүрээд авч явна".

Энэ хүн салыг үүрч авч явсан нь зөв үү? Үгүй ээ, буруу.

Энэ сургаал домог юу өгүүлнэ вэ гэвэл, "Зөв зүйтэй юманд хүртэл дасаж болохгүй, харин түүнээс татгалзах хэрэгтэй. Буруу ташаа юмны тухайд бол ярих ч хэрэггүй. Шууд л татгалзвал таарна".

3. Энэ орчлонд биднийг тойрон хүрээлж буй юм бүхэн хаанаас ч урган гарч ирэхгүй, хаашаа ч шингэж алга болохгүй, төрөхгүй, эвдэрч үхэхгүй, тийм учраас юуг ч олж, баттай эзэмшиж болдоггүй, юуг ч алдаж болдоггүй юм .

Бурхан багш сургасан нь: "Энэ ертөнцөд бүх юм "бий", "байхгүй" хэмээх ойлголтоос чөлөөтэй юм Тийм учраас эд юмс байна, байхгүй гэж алиныг нь ч хэлж үл болно. Тэдгээр юмс үл төрж, үл мөхдөг". Энэ нь ертөнцөд бүх юм цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүтэж, өөрийн гэсэн мөн чанаргүй тул тэдгээрийг оршиж буй хэмээн нотолж болохгүй. Тэдгээр нь цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүтэж, үнэхээр оршиж буй тул бас огт байхгүй гэж хэлж болохгүй.

Хэрэв эд юмсыг олж харчихаад тэдгээрт ээнэгшиж дасвал энэ нь санаа сэтгэлийн төөрөгдөл болно. Хэрэв эд юмсыг олж харчихаад тэдгээрт дотносон дасахгүй бол санаа сэтгэлд хүсэл шунал үл төрнө. Гэгээрэх нь энэхүү үнэнийг ухан ойлгож, сэтгэл санааны хүсэл шуналаас ангижирна гэсэн үг юм.

Орчлон хорвоо үнэхээр зүүд зэрэглээ мэт, үнэт эрдэнэ мөн адил хий үзэгдэл шиг юм. Бүх юм зурмал зураг дээр байгаатай адил. Хэдийгээр бид зураг дээр дээд, доод хэсэгт нь зурсан байхыг харах боловч, үнэн хэрэг дээрээ тэр бүхнийг нэг л хавтгай дэвсгэр дээр зурсан шүү дээ. Орчлон хорвоогийн бүх юм халуунд халсан агаар лугаа адил зэрэглээ болой.

4. Хэмжиж тодорхойлшгүй, нөхцөл нь бүрэлдэхэд

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

бүтэж буй болсон бүхнийг мөнх оршино гэж итгэх нь буруу үзэл бөгөөд түүнийг "Мөнх оршихын онол" гэнэ. Нөгөө талаар, энэ бүхэн замхарч алга болно хэмээх нь мөн буруу үзэл бөгөөд түүнийг "Үл оршихын онол" хэмээнэ.

Энэ бүх мөнхийн амьдрал ба үхэл, орших ба үл оршихын томьёолол нь эд юмсын үнэн зөв байдал бус юм. Хүн тэдгээрт дасаж ээнэгшсэн учир түүнд ингэж санагдаж буй билээ. Хэрэг дээрээ хорвоо ертөнцийн юм бүхэн нь дасаж дотноссон эсэхээс үл шалтгаалан оршиж байдаг.

Энэ ертөнцөд юм бүхэн цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд буй болох тул бүгд хувирч өөрчлөгдөнө. Эд юмс мөн чанаргүй учир мөнхийн хийгээд байнгын орших чанартай байж чадахгүй. Эд юмс үргэлж хувирах тул хий үзэгдэл, халуунд халсан агаар зэрэглээтэн үзэгдэх мэт билээ. Үүний хажуугаар тэдгээр нь үнэн чанартай. Тэдгээр нь мөнхийн хувирамтгай чанартай юм.

Гол мөрөн хүнд гол мөрөн гэж л харагдана. Гэтэл усыг гал хэмээн үздэг өлсгөлөн сүнс буюу бирдийн нүдэнд гол мөрөн хэмээн харагдахгүй. Тиймээс бирдийн хувьд гол ус "байхгүй байна", хүний тухайд "байна" гэж нотолж болохгүй.

Үүнтэй адил юуны ч тухай "Байна", "Байхгүй" хэмээж болохгүй. Учир нь бүх юм хий үзэгдэл билээ.

Түүгээр ч зогсохгүй энэхүү хий үзэгдэл бүхий ертөнцөөс өөр бодит ертөнц, мөнхийн ертөнц аль аль нь үгүй учир энэ орчлонг харьцангуй, цаг зуурын холбоо хэмээж бас болохгүй. Мөн энэ ертөнц бодит чанартай хэмээж үл болно.

Хүмүүс, алдаа дутагдлын учир шалтгаан энэ ертөнцөд оршино хэмээн боддог. Гэтэл энэ ертөнц хий үзэгдэл юм бол хүний сэтгэлд хүслийг төрүүлж чадахгүй, түүнээс болж хүн алдаа мадаг гаргах ёсгүй. Хүмүүс энэ үнэнийг эс мэдэж, эл ертөнцийг харьцангуй, эсвэл цаг зуурын, үгүй бол бодит хэмээн үздэгээс тэнэг алдаа гаргана.

Ухаантан хүн энэ үнэнийг ойлгож, хий үзэгдлийг хий үзэгдэл хэмээн үзэж, эл алдааг гаргадаггүй.

IV ДУНДАД ЗАМ МӨР

1. Бурхан багшийн сургаалыг дагаж буй хэн бүхэн амьдралын хоёр туйлаас зайлсхийх ёстой. Нэгдүгээрт, бузар булай хүсэлдээ автаж түүнийгээ хангах гэж хөөцөлдөхөөс сэргийл. Хоёрдугаарт, бие

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

махбод, санаа сэтгэлээ элдвээр сорьж, тарчлаан зовоож, хэт хатуу амьдралыг дээдлэхээс болгоомжил.

Амьдралын энэ хоёр туйлаас зайлж, билгийн нүдээ нээж, оюун ухааныг хөгжүүлж, гэгээрүүлдэг амьдралын дундад замыг баримтлах хэрэгтэй.

Дундад зам гэж юун буй. Энэ бол зөв зүйтэй найман мөрийн нэр юм. Үүнд: зөв үзэл, зөв бодол, зөв үгс, зөв үйлс, зөв амьдрах, зөв эрмэлзлэл, зөв дурсахуй, зөв төвлөрөхүй эдгээр болно.

Энэ хорвоод цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм бүтэж эвдэрдэг бөгөөд эд юмс оршиж байна, үл оршиж байна хэмээн алиныг нь ч нотолж үл болно. Нэг хэсэг тэнэг хүн эд юмс оршиж байна гэдэг, нөгөө хэсэг нь үл оршиж байна гэдэг. Харин зөв ухаарсан хүмүүс энэ бүхэн оршиж буй бус, үл оршиж буй бус хэмээдэг. Энэ нь чухамхүү эд юмсыг үнэн зөвөөр үзэх дундад үзэл юм.

2. Томоохон гуалин мод их мөрөнд хөвж явна хэмээн бодогтун. Хэрэв энэ гуалин баруун, зүүн эргийн алинд ч эс ойртвол, их мөрний тэхий дунд эс живбэл, усны хаялга түүнийг эрэг дээр эс гаргаж хаявал, хүн түүнийг эс барьж тогтоовол, эргүүлгэнд эс орвол, дотроосоо эс өмхөрвөл, хөвсөөр яваад

эцэст нь далай тэнгист хүрнэ.

Бурхан багшийн сургаалыг дагагч хэн ч гэсэн энэхүү гуалин лугаа адил дотоод, гадаад тал, орших, үл орших, зөв, буруугийн аль алинд эс дасаж, төөрөгдлөөс ангижиран ухаан санаагаа гагцхүү гэгээрэхийн тухай бодолд эс автуулж, харин гол мөрний яг тэхий дундуур нь хөвж явах ёстой. Энэ бол чухамхүү эд юмсыг үзэх дундад үзэл, амьдрах дундад арга юм.

Бурхан багшийн сургаалыг дагаж буй хүн бүхэн амьдралдаа хоёр туйлаас зайлсхийж, дундыг баримтлавал зохино.

Аливаа юманд ижилдэн дасч үл болно, орчлон хорвоод бүх юм үл эвдэрдэг, тодорхой шинж чанаргүй хэмээн мэдэх ёстой. Тэр ч байтугай өөрийнхөө сайн үйлд ч дасаж болохгүй.

Эс ижилдэн дасах нь аливаа юмнаас эс чаргууцалдах, аливаа юманд эс энэнгшин дасахын нэр юм. Бурхан багшийн сургаалыг баримтлагч хүн үхлээс үл айж, амьдрахыг эс гуйдаг. Тэрбээр янз бүрийн үзэл санааг эс дагадаг.

Хүн аливаа юманд ижилдэн дасмагцаа төөрөлдөж эхэлдэг. Тиймээс гэгээрэхийн зам мөрийг

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

баримтлан явж буй хүн юунд ч ижилдэн дасаж үл болно, аливаа юмнаас чаргууцалдаж үл болно, юуг ч хэт сониучирхан шохоорхож үл болно, юун дээр ч саатан зогсож үл болно.

3. Гэгээрэх нь илрэх тодорхой хэлбэргүй, өнгөгүй билээ. Тиймээс гэгээрэхэд гэгээрч буй юм үгүй .

Төөрөгдөх нь буй учраас л гэгээрэх нь байдаг, хэрэв төөрөгдөл үгүй болвол, гэгээрэл мөн адил алга болно. Төөрөгдөл үгүй бол гэгээрэл байхгүй, гэгээрэл үгүй бол төөрөгдөл байхгүй.

Тиймээс гэгээрэл буй нь нэг ёсны саад бэрхшээл юм. Харанхуй буй учраас гэрэл гэгээ гарах ёстой. Хэрэв харанхуй үгүй бол гэрэл гэгээ гарах ч хэрэггүй. Тэгсэн цагт гэрэл гэгээ ч үгүй , гэрэлтүүлэх зүйл ч үгүй болно.

Бурхан багшийн сургаалыг үнэхээр дагаж буй хэн ч гэсэн гэгээрчихээд түүндээ саатан зогсдоггүй. Учир нь гэгээрэл буй хэмээх нь төөрөгдөл билээ.

Тийм байдалд хүрвээс бүх юм төөрөгдөл мөн учраас гэгээрэл, бүгд харанхуй мөн учраас гэрэл гэгээ болно. Хорвоогийн хүсэл шунал бүхэн өөр юу ч бус, гагцхүү гэгээрэл болон хувиртал гэгээрэх хэрэгтэй юм.

4. Аливаа эд юмс хоорондоо ижил тэнцүү, тэдгээрийн хооронд ялгаа үгүй. Энэ ухагдахуун нь Шунъята буюу хоосон чанар юм. Аливаа эд юмс өөрийн мөн чанаргүй, тэд эс бүтэж, эс эвдэрдэг. Тэдгээрийг үгээр дүрслэн тодорхойлох аргагүй юм. Тиймээс тэдгээр нь хов хоосон билээ.

Гэгээрэх нь илрэх тодорхой хэлбэргүй, өнгөгүй юм. Тиймээс гэгээрэхэд гэгээрч буй юм үгүй.

Энэ хорвоод бүх юмс хоорондоо харилцан холбоотой, нэг нэгнээсээ шалтгаалан оршдог. Тэдгээр нь бусдаас үл шалтгаалан өөрсдөө оршиж чадахгүй.

Энэ нь гэрэл сүүдэр, урт богино, хар цагаан хоёр лугаа адил юм. Эд юмс өөрсдөө, бие даан оршиж үл чадна. Тэдгээр нь мөн чанаргүй юм.

Түүгээр ч зогсохгүй, төөрөгдөл үгүй бол гэгээрэл үгүй, гэгээрэл үгүй бол төөрөгдөл үгүй билээ. Энэ хоёр нь нэг нэгтэйгээ ҮЛ зөрчилдөх тул, эд юмс эсрэг тэсрэг чанаргүй билээ.

5. Хүмүүн бид эд юмс бүтэж, эвдэрч байна хэмээн боддог. Үнэн хэрэг дээрээ эд юмс эс бүтнэ, тийм болохоор эс эвдэрнэ.

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

Юмсын мөн чанарыг таних билгийн нүдтэй болсон хүн эд юмс үл бүтэж, үл эвдэрдэгийг мэдээд, үнэнийг сэхээрч, эдгээр нь тус тусдаа ялгаатай ойлголт бишийг ухаарна.

Хүн "би" байдаг хэмээн итгэдэг тул "миний" гэдэгтэй зууралддаг. Гэтэл үнэн хэрэг дээрээ "би" бээр үгүй учраас "миний" бээр мөн адил үгүй юм. Хүн "би", "миний" аль нь ч үгүйг мэдээд үнэнийг таньж, эдгээр нь өөр, өөр ялгаатай ойлголт биш болохыг мэддэг.

Ариун, бузар хоёр буй гэж үздэгээс хүн бүх юмыг ариун, бузар хэмээн хуваана. Гэтэл хэрэг дээрээ ариун, бузрын аль нь ч үгүй, тэдгээр нь хүний сэтгэлээс үүдсэн буруу ташаа төсөөлөл юм.

Хүн нүгэл, буян буй хэмээн бодож, бүхнийг нүгэл, буян хэмээн хуваадаг. Гэтэл дан ганц буян, дан ганц нүгэл гэж байхгүй. Гэгээрэх замыг дагаж буй хүн үнэнийг ухаарч буян, нүгэл нь ялгаатай бус гэдгийг ойлгоно.

Хүн гай зовлонгоос айж, зол жаргалыг хүснэ. Гэтэл гэгээрсэн оюунаар тунгаавал хүн гай зовлон бол чухамхүү зол жаргал мөнийг ухаарна. Хүн үнэнийг ухаарахдаа бие сэтгэлийг эзэмдэж, эрх чөлөөг боогдуулсан төөрөгдөл ч үгүй, мөн жинхэнэ

эрх чөлөө гэдэг ч үгүй хэмээн ойлгоно.

Тиймээс "Орших", "Үл орших", "Төөрөлдөх", "Гэгээрэх", "Чухал", "Чухал бус", "Зөв", "Буруу" хэмээн ярьдаг ч хэрэг дээрээ хоёр эсрэг тэсрэг ойлголт буй бус. Тэдгээрийн үнэн байдлыг үгээр илэрхийлэн дүрслэх, үзүүлж харуулах, ухаарч мэдэх бололцоо байхгүй. Харин үгс болон санаа сэтгэлийнхээ төсөөллийн эрхшээлээс гарах хэрэгтэй. Хүмүүс үг хийгээд төсөөллийн эрхшээлээс ангижирсан цагтаа жинхэнэ хоосныг онож ухаарна.

6. Үлгэрлэвэл лянхуа цэцэг цэмцгэр тал, өндөр ууланд бус, харин булингартсан намагт ургадаг билээ. Үүнтэй адил төөрөгдөл дунд хүн гэгээрч, буруу ташаа үзэл бодол, төөрөгдлөөс Бурхан болохын үр үндэслэдэг бүлгээ.

Элдвийн аюул саадыг давж, далайн ёроолд хүрч баймааж сая үнэт эрдэнэсийг түүхтэй адил төөрөгдлийн булингарт далайн ёроолд шумбаж баймааж гэгээрэхийн үнэт эрдэнэсийг олно. Хүний өөртөө дассан сэтгэл нь уул нуруу адил агуу том боловч, хэрэв Бурхан багшийн сургаалыг дагахаар сэтгэл шулуудвал ямар ч байсан гэгээрнэ.

Эрт урьд цагт мэргэд шовх шовх үзүүртэй хадан дээр гараад эс шархтаж, дүрэлзэн асч буй галд ороод

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

эс түлэгдэж, эс үхэж үрэгддэг байсантай адил, харин ч үргэлж цовоо сэргэлэн байсны адил, Бурхан багшийн сургаалыг дагаж буй хүн нэр төр, алдар гавьяаны шовх шовх хад асган дээр гарсан ч, үзэн ядах сэтгэлийн галд орсон ч гэгээрлийн ариухан салхи сэвэлзэхийг мэдэрнэ.

7. Бурхан багшийн сургаалыг дагасан хүн үнэнийг ухаарч, эсрэг тэсрэг ухагдахуун нь өөр өөр бус, угтаа нэг л мөн чанартайг ойлгоно. Эсрэг тэсрэг ойлголтоос нэгийг нь салгаж, түүнийгээ эс тавин зууралдваас тэр ухагдахуун нь буян буюу зөв үзэл байсан ч алдаа болно.

Хорвоо ертөнцөд бүх юм өөрчлөгдөн хувирна гэсэн үзэл санааг хатуу баримталбал энэ нь мөн алдаа болно. Ертөнцөд юу ч хувиран өөрчлөгдөхгүй гэсэн үзлийг чанд дагавал энэ нь бүр ч том алдаа болно. Хэрэв "би" бээр буй хэмээн хатуу итгэвэл алдаа болж, хүн зовлонгоосоо салж чадахгүй. Хэрэв "би" бээр буй бус хэмээн чанга итгэвэл энэ нь бас алдаа болж, тийм хүн Бурхан багшийн сургаалыг дагах утга учиргүй болно.

Энэ ертөнцөд бүх юм зовлон зүдүүр хэмээн хөдөлшгүй итгэвэл энэ нь алдаа болно. Энэ ертөнцөд бүх юм баяр баясгалан хэмээн хөдөлшгүй итгэвэл энэ нь бас алдаа болно. Бурхан багшийн сургаал

Сэтгэл Санаа Болон Эд Юмсын Үнэн Байдал

дундад замыг зааж, аливаа туйлшралаас зайлсхийхэд сургадаг.

III БӨЛӨГ

ГЭГЭЭРЭХИЙН ҮР

I

АРИУН НАНДИН СЭТГЭЛ

1. Орчлон хорвоод янз янзын хүмүүс байдаг. Санаа сэтгэл нь манантаж эхэлсэн, санаа сэтгэл нь бүр манантчихсан хүмүүс аль аль нь буй. Ухаантай хүмүүс буй, тэнэг хүмүүс ч буй.

Сайхан сэтгэлтэй хүмүүс, атгаг санаатай хүмүүс ч буй. Нэг хэсгийг нь зааж сургахад амархан, нөгөөг нь хэцүү байдаг.

Хүмүүсийг өнгө өнгийн лянхуа цэцэгтэй үлгэрлэж болно. Тэднийг тогтмол усанд ургадаг цэнхэр, улаан, шар, цагаан олон өнгийн лянхуатай зүйрлэж болно. Тэдгээр нь цугаараа усанд ургадаг хэдий ч нэг хэсэг нь усан доор, нөгөө нь усны гадаргуу дээр, гурав дахь нь уснаас дээш, усанд хүрэлгүй ургадаг билээ.

Түүнээс гадна хүмүүс хүйсээрээ ялгагдана. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс буй. Гэвч бүх хүмүүсийн мөн чанар адилхан юм. Бурхан багшийн сургаалыг дагасан эрэгтэй хүн гэгээрч болохтой адил, сэтгэл юугаа ариусган төгс төгөлдөр болгож буй эмэгтэй хүн ч гэгээрнэ.

Зааныг унаж сурахад итгэл, эрүүл мэнд, хичээл зүтгэл, шулуун шударга зан, саруул ухаан хэрэгтэй. Бурхан багшийг дагаж гэгээрэхийн тулд эдгээр таван чанар мөн шаардагдана. Дээрх таван чанар буй бол бурхан багшийн сургаалыг эзэмшихэд цаг хугацаа их шаардагдахгүй. Учир нь бүх хүн гэгээрэх мөн чанартай төрсөн билээ.

2. Гэгээрэх явцдаа Бурхан багшийг хүн нүдээрээ харж, түүнд зүрх сэтгэлээрээ сүсэглэн итгэнэ. Гэвч Бурханыг олж харах өнөө нүд, түүнд сүсэглэн итгэх өнөө зүрх сэтгэл эдүгээ хүнийг амьдрал, үхлийн ертөнцөд хөтлөн явж байна.

Дээрэмчдийг бут цохихын тулд эзэн хаан юуны түүрүүнд тэдний үүр хаа байгааг олж мэдэх ёстой. Үүнтэй адил төөрөгдлийг устгахын тулд түүний нүд, зүрх сэтгэл нь хаана буйг олж мэдэх хэрэгтэй.

Хүн тасалгаанд нүдээ нээхдээ юуны өмнө тэнд буй эд юмсыг олж хардаг. Дараа нь цонхоор харж, цонхны цаана буй юмыг үздэг. Тасалгаанд буйг олж хараагүй мөртлөө цонхны цаадахыг олж харна гэж үгүй.

Хэрэв бие махбод дотор санаа сэтгэл оршдогсон бол тэрбээр эхлээд бие доторхийг сайн харах байсан билээ. Гэтэл хэрэг дээрээ хүн бие махбодынхоо

Гэгээрэхийн Үр

гаднахыг л сайн мэддэг бөгөөд бие махбод дотроо юу байдгийг бараг мэдэхгүй.

Хэрэв санаа сэтгэл бие махбодынхоо гадна байсан бол тэдгээр нь тусдаа орших байсан агаад санаа сэтгэл нь бие махбодын мэддэгийг мэдэхгүй, бие махбод нь санаа сэтгэлийнхээ мэддэгийг мэдэхгүй байхсан. Үнэн хэрэгтээ санаа сэтгэлийнхээ мэддэгийг бие махбод мэдэрч, бие махбодынхоо мэдэрдэгийг санаа сэтгэл нь мэддэг. Тиймээс санаа сэтгэл нь бие махбодын гадна байдаг хэмээж үл болно. Тийн аваас санаа сэтгэлийн мөн чанар хаана оршдог вэ?

3. Тэргүүлшгүй цагийн чанадаас эхлээд бүх хүн өөрсдийнхөө үйлийн үрээр холбогдож, хоёр зүйлийг мэддэггүй учраас төөрөлдөж байдаг.

Нэгдүгээрт, хүмүүс төрөх, үхэхийг үзэж хардаг төөрөлдсөн сэтгэлээ өөрсдийн мөн чанар гэж үздэг. Хоёрдугаарт, гэгээрэхийн мөн чанар болсон ариун цагаан сэтгэл нь төөрөлдсөн сэтгэлийнхээ сүүдэрт нуугдаж, өөрсдийнх нь дотор оршдогийг үл мэднэ.

Хүн гараа зангидаж нударгаа дээш өргөхөд түүний нүд харж, сэтгэл мэдэж авдаг. Гэвч энэ сэтгэл бол жинхэнэ сэтгэл биш.

Элдвийг санаархаж буй санаа сэтгэл хүслээс ургана. Энэ сэтгэл нь өөрийнхөө ашиг хонжоог л урьтал болгоно. Энэхүү санаа сэтгэл цаг нь болж, нөхцөл бүрэлдсэний улмаас хөөрөн дэвэрч үргэлж хувирч байдаг, жинхэнэ мөн чанаргүй билээ. Хүн өөрөө санаа сэтгэлээ мөн чанартай гэж итгэснээс төөрөгдөл үүснэ.

Хүн гараа атгахаа больж, хуруугаа тэнийлгэхэд санаа сэтгэл нь хуруунууд тэнийснийг мэднэ. Ингэхэд юу хөдөлгөөнд орно вэ? Гар уу? Санаа сэтгэл үү? Эсвэл аль нь ч биш үү?

Гар хөдөлж байвал санаа сэтгэл мөн хөдөлж байгаа билээ. Эсвэл санаа сэтгэлийн хөдөлгөөн гарт шилжиж байгаа юм. Гэвч хөдөлж буй санаа сэтгэл нь гүн гүнзгий оршдог бус, гүехэн өнгөц оршдог сэтгэл юм.

4. Бүх хүн ариун тунгалаг жинхэнэ санаа сэтгэлтэй билээ. Тэр сэтгэл нь гадаад нөхцөлөөс шалтгаалан буй болдог төөрөгдлийн тоосонд хучаастай байдаг. Гэвч төөрөгдөж буй санаа сэтгэл гол бус, хоёрдогч чанартай юм.

Хэдийгээр үүлс сарыг хэсэг зуур хаадаг ч, түүнийг бохиртуулж хиртүүлэхгүй, байрнаас нь ч хөдөлгөхгүй.

Гэгээрэхийн Үр

Тиймээс хүн мөн чанараа салхинд боссон бөөн тоосон үүл лүгээ адил төөрөлдсөн санаа сэтгэл мөн хэмээн бодож болохгүй.

Хүн үл хөдлөгч, үл бузартсан, жинхэнэ санаа сэтгэлээ түргэн олж, өөрийнхөө мөн чанарт эргэн орох ёстой. Хүн хувиран өөрчлөгдөх, төөрөлдсөн сэтгэлийнхээ эрхэнд байдаг тул, эд юмыг буруугаар үзэж, тиймээс ч төөрөгдлийн далайд зүг чигээ олохгүй самуурдаг.

Үргэлж хувиран өөрчлөгдөгч гадаад шалтгаан, хүсэл шуналын улмаас хүний санаа сэтгэл төөрөлдөн бузартдаг билээ.

Мөнхийн үл хөдлөх, үл эвдрэх, гадаад шалтгаанд үл автах санаа сэтгэл бол хүний мөн чанар, гол санаа сэтгэл нь юм.

Буудалласан хүн буцахад дэн буудал нь алга болохгүйтэй адил, гадаад нөхцөл шалтгааны улмаас буй болж, алга болж, элдвийг санаархаж байдаг сэтгэл үгүй боллоо гээд хүн алга болохгүй. Гадаад нөхцөл байдлаас болж өөрчлөгдөх санаа бол хүний сэтгэлийн мөн чанар бус юм.

5. Уужим танхим байна гэж бодъё. Нар мандах үед танхим гэрэлтэж, нар жаргахад харанхуй болно.

Гэрэл гэгээг нартай, харанхуйг шөнөтэй холбож болно. Гэвч бид гэрэл, харанхуйг танин мэдэхэд тус болдог хүчийг юутай ч холбож үл чадна. Гагцхүү санаа сэтгэлийн мөн чанартай холбохоос өөр аргагүй юм.

Нар мандаж, бид гэрэл гэгээг олж харах нь санаа сэтгэл хоромхон зуур илэрч байгаа хэрэг. Нар жаргаж, харанхуйг олж харах нь бас санаа сэтгэл хоромхон зуур илэрч байгаа хэрэг. Гэтэл харанхуй мэтийн гадаад нөхцөл шалтгаан нь гэрэл, харанхуйг ялгадаг бидний сэтгэлийг дуудан гаргаж ирдэг. Гэвч энэ нь санаа сэтгэлийн түр зуурын илрэл бөгөөд санаа сэтгэл өөрөө бус, түүний мөн чанар бус билээ. Гэрэл, харанхуйг ялгагч хүчний эх булаг бол санаа сэтгэлийн мөн чанар юм.

Гадаад нөхцөл шалтгааны улмаас буй болж, бас алга болох буян нүглийн ойлголт хийгээд хайрлах, үзэн ядах сэтгэл нь хүний сэтгэлд хуримтлагдсан хир бузраас үүдэн буй санаа сэтгэлийн түр зуурын илрэл юм.

Хэдийгээр хорвоогийн хүсэл шуналын тоосонд дарагдсан ч хиртэж, бузартаагүй үнэхээр ариун тунгалаг санаа сэтгэл байдаг.

Бөөрөнхий саванд буй ус бөөрөнхий, дөрвөлжин

Гэгээрэхийн Үр

саванд буй ус дөрвөлжин санагдана. Гэвч ус мөн чанартаа бөөрөнхий ч бус, дөрвөлжин ч бус. Хүмүүс үүнийг мартаж усыг гагцхүү хэлбэрээр нь дүгнэдэг. Хүмүүс буян, нүгэл, хайрлах, үл хайрлах, орших, үл орших зэрэг ухагдахууны хүлээсэнд баригдаж гадаад хэлбэрийг хөөцөлдөн зовж зүдэрдэг.

Хэрэв гадаад нөхцөл шалтгаанаас ангижран салж, өөрийн жинхэнэ чөлөөт мөн чанарыг олвол, бие махбод, санаа сэтгэл ямар ч хүлээсэнд авталгүй, бүрэн эрх чөлөөгөө олно.

II НУУЦ ЭРДЭНЭ

1. Ариун тунгалаг, жинхэнэ санаа сэтгэл бол зүйрлэн хэлбэл Бурхан багшийн мөн чанар буюу Бурхан багшийн үр юм.

Бид томруулдаг шил авч нарны олон сая, живаа туяаг нэгэн багц болгон зулын голд тусгахад ямар учраас асдаг вэ? Хаанаас гал гарч ирдэг вэ? Нар, томруулдаг шил хоёр нэг нэгнээсээ алс хол учир нэг бие болон нэгдээгүй гэлээ ч нарны туяа нь томруулдаг шилийн тусламжтайгаар зулын голыг асаасанд хэн ч үл эргэлзэнэ. Гэтэл нарны туяа зулын гол дээр туслаа ч, хэрэв тэр нь үл асах чанартай бол

асгахгүйсэн билээ.

Хэрэв Бурхан багшийг төрүүлдэг Бурхан багшийн мөн чанарын зулын голд Түүний оюун гал нь хүн-зулын голыг асааж, Бурхан багшийн мөн чанарыг нээгч итгэл бишрэлийн гал болон бадран дүрэлзэнэ.

Бурхан багш өөрийн оюун ухааны томруулагч шилийг ертөнцөд тусгадаг тул энэ ертөнцөд итгэл бишрэлийн гал дүрэлзэн асдаг.

2. Хэдийгээр бүх хүн төрөлхөөсөө гэгээрэх үрийг өөртөө агуулдаг ч, хүмүүс хорвоогийн шунал тачаалын тоосны үүл мананд төөрч, сайн, муу хэмээх ойлголтын эрхшээлд автаж бачимддаг билээ.

Хүмүүс төрөлхөөсөө гэгээрэх санаа сэтгэлийг агуулдаг мөртлөө яагаад буруу ташаа төсөөлөл буй болгож, Бурхан багшийн гэрэл гэгээнээс зайлж, төөрөгдлийн ертөнцөд хэрэн хэснэ вэ?

Эрт урьд цагт нэг хүн өглөө эрт босч, өөрийгөө толинд харж, нүүр царай, толгойгүй болсноо үзээд сандарчээ. Гэвч түүний нүүр царай, толгой нь алга болоогүй, тэрбээр толио буруу харуулж, өөрийгөө ар талд нь харж тийнхүү эндүүрчээ.

Гэгээрэхийн Үр

Хүсэн хичээвч гэгээрч чадахгүй нь гээд зовж шаналах бол тэнэг явдал юм. Ингэх шаардлагагүй. Гэгээрэлд төөрөгдөл байхгүй, гэвч хүн эцэс төгсгөлгүй цаг хугацааны турш гадаад тоосонд дарагдахдаа, төсөөлөл таамаглалын ертөнцөд амьдарч, улмаар өөртөө төөрөгдлийн ертөнцийг бүтээн буй болгожээ.

Тиймээс хүн төсөөллийн ертөнцөө орхиж чадвал, төвөггүй гэгээрч, гэгээрлээс өөр төсөөллийн ертөнц байхгүйг ухаарна. Гэвч гэгээрсэн хүний хувьд төсөөллийн ертөнц нэгэнт алга болж, тэрбээр юунд ч гэгээрэх хэрэггүйг ухаарах нь юу юунаас илүү гайхалтай.

3. Бурхан багшийн энэхүү мөн чанар үүрд мөнх оршдог. Ертөнцөд хүн, амьтны төрхийг олж төрсөн ч, эсвэл бирд буюу өлсгөлөн сүнс болж төрөөд зовж зүдэрсэн ч, тамд унасан ч гэсэн Бурхан багшийн мөн чанар мөнх оршино.

Бузартсан бие махбод, хорвоогийн шунал тачаалын хир буртаг бүхий ёроолд унавч Бурхан багшийн мөн чанар нь гэрэл гэгээ цацраасан хэвээр байна.

4. Эрт урьд цагт нэгэн хүн найзындаа очихоор явжээ.

Тэрбээр дарс ууж согтоод, найзындаа унтжээ. Түүнийг нойрсож ахуй үед найзад нь яаралтай ажил гарч аянд оджээ. Гэвч явахынхаа өмнө найзыгаа бодож, дээлийнх нь заханд эрдэнэ нууж оёсон аж.

Түүнийг мэдээгүй нөхөр нь унтаж босоод олон орноор хэрэн хэсч, идэх хоол, уух усгүй явж байлаа. Чингээд найзтайгаа тааралдахад цаадах нь дээлийнхээ заханд буй эрдэнийг хэрэглэ хэмээжээ. Энэхүү домог үлгэр лүгээ адил Бурхан багшийн мөн чанарын эрдэнэ бол хүсэл шунал, уур уцаар зэрэг хорвоогийн тачаалын дээлийн заханд нууц далд буй бөгөөд хэзээ ч өнгө алддаггүй билээ.

Энэ ертөнцөд Бурхан багшийн оюун ухаангүй төрсөн нэгээхэн бээр ч хүн байхгүй. Гиймээс Бурхан багш харцаараа хүмүүсийг цоо ширтэхдээ: "Бүх хүн Бурхан багшийн оюун ухаан, бодь чанаруудыг өөртөө агуулдаг нь юутай сайхан бэ!" гэж баясан баярладаг.

Гэвч хүмүүс мунхагийн харанхуйд автаж, эд юмсыг ёсоор нь эс харж, өөрт нь Бурхан багшийн мөн чанар буйг эс үзэх учир Бурхан багш хүмүүсийг сургаж, тэднийг төсөөллийн ертөнцөөс ангижруулж, тэд төрөлхөөсөө Бурхан багшаас өчүүхэн бээр ялгал үгүй хэмээн ойлгуулдаг.

5. Энд бидний ярьж буй Бурхан багш бол Бурхан

Гэгээрэхийн Үр

багш болсон хүн юм. Ирээдүйд бүх хүн мөн адил Бурхан багш болно, өөр хэн ч болохгүй.

Хэдийгээр тэд Бурхан багш болох ёстой ч, одоохондоо болоогүй байгаа билээ. Хэрэв хэн нэг нь Бурхан багшийн сургаалыг ухаарч таньсан гэж бодвол их л алдаж байгаа хэрэг.

Хэдийгээр бүх хүнд Бурхан багшийн мөн чанар буй боловч хүн Бурхан багшийн сургаалыг ухаартал тэр чанар нь үл илэрнэ. Тэр чанар үл илэрнэ гэдэг нь Бурхан багшийн сургаалыг тэр ХҮН ухаараагүй гэсэн үг.

6. Эрт урьд цагт нэгэн хаан амьдарч байжээ. Тэрбээр сохор хүмүүсийг дуудан цуглуулж, цугааранд нь нэгэн зааныг барьж үзэхийг тушааж, дараа нь хүн бүрээс зааныг хэрхэн төсөөлж байгааг лавлажээ. Зааны соёог барьж үзсэн сохор хүн хэлэхдээ, заан томоос том лууван лугаа адил гэжээ. Чихийг нь барьж үзсэн хүн, заан дэвүүр лүгээ адил хэмээжээ. Хушуугий нь оролдсон хүн өчихдөө, заан томоохон нүдүүр лүгээ адил хэмээжээ. Хөлийг нь оролдсон хүн, заан том гуалин мод лугаа адил гэжээ. Сүүлийг нь барьж үзсэн хүн, заан нь олстой адилхан гэжээ.

Нэг ч сохор хүн зааны тухай зөв төсөөлөл олж

аваагүй аж.

Үүнтэй адил хүнийг оролдож үзээд, биений нь зарим хэсгийг тодорхойлж болох ч, түүний мөн чанарын тухай буюу Бурхан багшийн мөн чанарын тухай зөв, оновчтой хэлэхэд туйлын хэцүү.

Хүн үхэхэд эс алдагдах, хорвоогийн шунал тачаалд өнгөө үл алдах, мөнх оршдог Бурхан багшийн мөн чанарыг гагцхүү Бурхан багш, Түүний сургаалын хүчээр л олж болно.

III АЛИВАА ДАСАХЫН ХҮЛЭЭСНЭЭС АНГИД БАЙХ

1. Хүн бүр Бурханы мөн чанартай. Үүнийг зарим хүн бусад сургаалд номлодог "Би"-тэй эндүүрнэ. Үүгээрээ тэд асар их алдаж байгаа юм.

"Би" нь дасаж дадахтай холбоотой, гэтэл гэгээрсэн хүн бол "би"-гээсээ, дасал болсон юмнаасаа ангижрах ёстой. Бурхан багшийн мөн чанар бол олох ёстой эрдэнэ лүгээ адил. Тэр нь "би"-тэй адил боловч "би", "миний" гэж ярихдаа бидний ойлгож байдаг тэр "би" бус юм.

Өөрийнх нь "би" буй гэж боддог хүн, үл оршиж

Гэгээрэхийн Үр

буйг оршиж буй хэмээн эндүүрснээрээ алдаж байна. Бурхан багшийн мөн чанар байхгүй гэж үздэг хүн оршиж буйг үл оршиж буй хэмээн эндүүрч байгаа юм.

Үлгэрлэвэл, манай хүүхэд өвджээ гэж бодъё. Эмчид үзүүлвээс эм өгөөд, хүүхдийн бие нь эмийг шингээтэл сүү өгч болохгүй гэжээ.

Эх нь хүүхэд хөхөө үлгэхээс сэргийлж, товчийг нь гашуун тосоор тосолжээ. Хүүхдийн бие эмийг бүрмөсөн шингээсний дараа эх нь хөхөө угааж үрээ хөхүүлжээ. Хүүхдээ хайрласны учир л ингэсэн ажгуу.

Энэхүү домогт гарч буй эхтэй адил хүмүүсийн алдааг засаж, өөрийн "би"-д дасаж дадахаас нь ангижруулахын тулд Бурхан багш "би" бээр байхгүй хэмээн сургасан аж. Харин Тэрбээр хүмүүсийн алдааг зассаныхаа дараа Бурхан багшийн мөн чанар буй хэмээн номлож эхэлсэн юм.

"Би" хэмээх нь төөрөгдөлд хүргэдэг бол, Бурхан багшийн мөн чанар гэгээрэлд хүргэнэ.

Гэрт нь дүүрэн алт бүхий авдар буйг мэдээгүй ядуу хоосон эмэгтэйг өрөвдөж, түүнд авдрыг нь ухаж авч өгсөн хүн лүгээ адил Бурхан багш, хүний доторхи Бурхан багшийн мөн чанарыг нээж,

хүмүүст харуулна.

2. Тэгвэл хүмүүс Бурхан багшийн мөн чанартай мөртлөө яагаад дээд, доод зиндааны, баян, ядуу хэмээн хуваагдана вэ? Тэд яагаад амьтны аминд халдаж, нэг нэгнийгээ хууран мэхэлж, бусад буруу үйл хэргийг үйлддэг юм бэ?

Ордны нэгэн хүч тэнхээтэй эр байжээ. Нэгэнтээ тэрбээр магнайгаа гоёж зүүсэн эрдэнийн чулуун шигтгээгээ авалгүй барилджээ. Тэрбээр духаараа хүчтэй мөргөхөд эрднийн шигтгээ хамрын хянганы арьсан доогуур гүнзгий шигдэн орж, хөндүүр болгожээ. Хүчтэн эр эрдэнийн шигтгээгээ гээчихсэн хэмээн бодож, эмчид бараалхаж, өвдөж буй газраа эмчлүүлэхийг хүсчээ. Эмч түүнийг хараад л эрдэнийн шигтгээ арьсан доор нь гүнзгий шигдэн орсноос болж өвдсөнийг нь ойлгов. Тэгээд эрдэнийн чулуун шигтгээг чимхэн гаргаж хүчтэнд харуулжээ.

Үүнтэй адил хүмүүст буй Бурхан багшийн мөн чанар хорвоогийн элдэв шунал тачаалын зузаан тоосон дор буй учраас өөрсдөө үл анзаардаг. Мөн чанараа олж харах нүдийг нь сайн багш нээж өгдөг.

Тиймээс хүмүүс Бурхан багшийн мөн чанартай боловч, шунал, уур хилэн, мунхаг сэтгэлээсээ болж бурханы чанар өөрт нь буй тухай санаанд нь ч

Гэгээрэхийн Үр

багтдаггүй юм. Өөрсдийн үйлдсэн үйл, үйлийн үр нь тэднийг төөрөгдлийн эрхэнд оруулдаг. Гэвч Бурхан багшийн мөн чанар алдагдахгүй бөгөөд эвдрэхгүй. Төөрөгдөл нь арилмагц тэр нь тодоос тод гялалзах өнгөт од лугаа адил гэрэлтэнэ.

Үлгэр домгийн хүчтэн, эмчийн ачаар эрдэнийн шигтгээгээ олсон лугаа адил хүмүүс Бурхан багшийн гэрэл гэгээний ачаар өөртөө буй Бурхан багшийн мөн чанарыг олдог.

3. Хэдийгээр хар, цагаан, хүрэн зэрэг олон зүсмийн үхэр байвч, цугаараа ижилхэн цав цагаан сүүтэй. Үүнтэй адил хүмүүс өөр өөр нөхцөлд амьдарч, төрөл бүрийн аргаар аж төрж, үйлийнхээ хариуд янз янзын үйлийн үрийг амсдаг ч тэд цугаараа ижилхэн Бурхан багшийн мөн чанартай юм.

Үлгэрлэвэл, Хималайн ууланд үнэт эмийн ургамал байдаг боловч, өтгөн өвс ширэнгэний гүнд нь ургадаг тул хүмүүс олж үл чадна. Эрт урьд цагт нэгэн мэргэн хүн эмийн ургамлыг үнэрээр нь олж, модоор сав үйлдэж, эм тангаа дотор нь хийжээ. Гэвч түүнийг нас барсны дараа эм танг нь ууланд мартсанаас модон саван дотроо муудан ялзарч савнаасаа асгарчээ. Эмийн амт нь ч өөр болсон байлаа.

Энэхүү домогт гардаг лугаа адил Бурхан багшийн мөн чанар нь хорвоогийн шунал тачаалын өтгөн өвс ширэнгэн дунд гүн гүнзгий нуугдаж байдаг бөгөөд хүмүүс түүнийг олоход хэцүү юм. Гэвч энэ удаа Бурхан багш өвс ширэнгийг ярж, түүнийг хүмүүст үзүүлэв. Бурхан багшийн мөн чанар үргэлж чихэр бурам лугаа адил амттай байдаг боловч, хорвоогийн шунал тачаалын улмаас хүмүүст өөр өөр амттай санагддаг учир хүмүүс янз анзаар амьдардаг.

4. Бурхан багшийн мөн чанар эрдэнийн чулуу алмаз лугаа адил хатуу учраас эвдрэхгүй. Элс юм уу, эсвэл чулууг цоолж нүх гаргаж болох авч, алмаз чулууг цоолж нүх гаргаж үл болно.

Хэдийгээр хүний бие махбод, сэтгэл санааг эвдэж болох боловч Бурхан багшийн мөн чанарыг эвдэж үл болно.

Бурхан багшийн мөн чанар бол хүний хамгийн сайн шинж чанар юм. Хүмүүс эрэгтэй хүн, эмэгтэйчүүдээс илүү, эмэгтэй хүн эрэгтэй хүнээс доор гэж үздэг билээ. Харин Бурхан багшийн сургаалын дагуу эрэгтэй, эмэгтэй хүний хооронд өчүүхэн бээр ялгаа байхгүй юм. Энэхүү сургаал Бурхан багшийн мөн чанарыг үнэлж хүндэлдэг байхыг зааж сургана.

Хэрэв бохир алтыг хайлуулан хольцыг авбал

Гэгээрэхийн Үр

шижир нь тунана. Хэрэв хүний сэтгэлийн бохир алтыг хайлуулж, хорвоогийн шунал тачаал хэмээх хольцыг ялгавал, аливаа хүний дотор Бурхан багшийн мөн чанар ижилхэн тунаран тодорно.

IV БӨЛӨГ

НИСВААНИС

I

СЭТГЭЛИЙН БУЗАР

1. Хүний сэтгэлд буй Бурхан багшийн мөн чанарыг ухааны болон зүрх сэтгэлийн хэмээх хоёр шунал тачаал хучсан байдаг.

Ертөнцийн бүх шунал тачаалыг энэхүү хоёр төрөлд хуваана. Үүсэх шалтгаан нь мунхаг харанхуй болон шунахай сэтгэл юм.

Харанхуй болон ховдог хомхой сэтгэл бүх шунал тачаалыг өдөөнө. Эдгээр нь ямар ч шунал тачаалын эх ундарга болой.

Харанхуй гэдэг нь мунхаг ухаан хийгээд үнэнийг үл ойлгох байдал юм. Ховдог хомхой сэтгэл бол хүсэд шунал, амьдралд дасал болохын эх ундарга юм. Энэ бол нүдээр харж, чихээр сонсч буй бүхнээ эзэгнэх хүслэн юм. Энэ бол үхлийн хүслэн болж өсч ургадаг хүслэн билээ.

Харанхуй хийгээд ховдог хомхой сэтгэлээс эгээрэл хүсэл, уур уцаар, мунхаг ухаан, буруу тайлбар, гомдол, атаархал, худал хуурмаг, бялдууч зан, ихэмсэг зан, бусдыг үл тоомсорлох, хөнгөн

Нисваанис

Хийсвэр загнах зэрэг хорвоогийн шунал тачаал төрнө.

2. Хүн өөрт нь таалагдсан юмыг олж хараад хүслээ хангах буруу бодолд автахад шунал үүснэ. Хүн өөртөө үл таалагдах юмыг олж харахдаа эрхэндээ оруулах гэсэн буруу бодолд автахад уур хилэн үүснэ. Хүн харанхуйгаасаа болж юу хийх ёстой, юу хийх ёсгүйгээ үл мэдэх нь мунхаг явдал юм. Буруу сургаалын нөлөөн дор буруу бодох нь буруу тайлбарлахад хүргэнэ.

Хүсэл шунал, уур хилэн, мунхаг харанхуй гурвыг энэхүү ертөнцийн гурван гал хэмээдэг. Бүх хүслээ дураар нь тавьж ухаан бодлоо хазаарлах чадваргүй болсон хүний хүслийн гал нь шатаадаг. Амьд амьтныг хөнөөж, уурын мунхагт автсан хүнийг хилэнгийн гал нь шатаадаг. Бурхан багшийн сургаалыг мэдэхгүй, төөрөлдөж яваа хүнийг мунхагийн гал хуйхалдаг.

Үнэхээр энэ орчлонд янз янзын гал асч буй билээ. Хүсэл шунал, уур хилэн, мунхаг ухааны гал, амьдрах, өтлөх, өвдөх, үхэхийн гал, санаа сэтгэл шаналж, уйтгарлан гуних, зовж зүдрэх, тарчлахын олон гал асч байна. Ертөнцийн шунал тачаалын хорт гал зөвхөн төөрч будилсан хүмүүсийг хуйхлаад зогсохгүй, бас бусдыг зовоож, бие, хэл, сэтгэлээр нүгэл үйлдэхэд хүргэдэг. Үүгээр ч

зогсохгүй энэ галд түлэгдсэнээс үүдсэн идээ бээр нь бусад хүмүүст халдварлаж, тэднийг муу үйлийн замд хөтлөн оруулна.

3. Шунал хүсэл нь хангалуун байх гэсэн сэтгэлээс, уур хилэн нь сэтгэл хангалуун бишээс, мунхаг харанхуй нь муу муухай санаанаас үүднэ. Хэдийгээр шунал хүсэл нь сүйдтэй том нүгэд биш боловч, түүнээс ангижирна гэдэг амаргүй. Хэдийгээр уур хилэн нь их нүгэд боловч, түүнээс ангижирах нь хэцүү биш. Мунхаг харанхуй бол том нүгэл, түүнээс ангижрах нь амаргүй.

Тиймээс хүмүүс өөртөө таалагдаж буй юмыг үзэх, сонсох үедээ зөв бодож сэтгэх, тааламжгүй зүйлийг үзвэл тэвчихийг дээдэлж ямагт зөв бодох, ингэснээрээ муу гурван галыг унтраах ёстой. Хүмүүс зөв, ариун тунгалаг, өгөөмөр сайхан сэтгэлтэй болвол хорвоогийн шунал тачаал тэдэнд үгүй болно.

4. Шунал хүсэл, уур хилэн, мунхаг харанхуй нь өвчтөн халуурах лугаа адил билээ Ямар ч саруулхан, гоё тансаг өрөөнд хэнбугай ч хэвтэж байсан, халуунтай л бол дэмийрч, нойр муутай хононо.

Хорвоогийн эдгээр шунал тачаалаас ангижирсан

Нисваанис

хүн хөхөө өвлийн хүйтэн шөнө, газар унаж дэрийн хөлдсөн навчисын дээр ч гэсэн тайван тухтай нойрсоно. Зуны бүгчим шөнө, тав тух муутай, бачуухан өрөөнд ч сайхан унтана.

Ертөнцийн энэхүү гурван шунал тачаал эл хорвоогийн уй гуниг, зовлон зүдүүрийн гол шалтгаан билээ. Энэ уйтгар гуниг, зовлон зүдүүрийг гагцхүү сонор сэрэмж, сэтгэл санааны төвлөрөл, оюун ухаан л таслан зогсооно. Сонор сэрэмж нь шунал хүслийн, санаа сэтгэлийн зөв төвлөрөл нь уур уцаарын, оюун ухаан нь харанхуй мунхгийн бузрыг арилгана.

5. Хүний хүсэл аливаа хязгаарыг үл мэднэ. Зүйрлэвэл, энэ нь давстай ус уугаад, цангаа тайлж чадахгүй байгаа хүнтэй адил бүлгээ. Тэрбээр хичнээн их ус уулаа ч, цангаагаа тайлж чадахгүй, улам ангана.

Хүн хүслээ хангахаар тэмүүлэвч сэтгэл нь улам бүр үл ханаж, уурлаж уцаарлаж эхэлнэ.

Хүн хүслээ хангаж чадахгүй. Тэрбээр хүслээ биелүүлж чаддаггүй учир зовж зүдэрдэг. Тэрбээр хүсэл нь биелэхгүй болохоор галзуурах шахдаг.

Хүмүүс ховдог хомхой сэтгэлээсээ болж нэг нэгтэйгээ маргалдаж, хоорондоо дайтна. Ховдог

хомхой сэтгэлдээ автаж урдахаа харахаа больсон хаад ноёд, сайд язгууртан, эцэг хөвгүүд, ах дүү, анд иөхөд хоорондоо тэрсэлдэн дайтаж, нэгийгээ алж хяддаг.

Шунаг сувьдаг сэтгэлээсээ болж хүн зөв замаасаа урваж, хулгай хийж, худал хэлж, буруу хурьцаж эхэлдэг. Зарим үед гэмт хэрэг үйлдэж байгаад баригдан шийтгэгдэж, зовж тарчилдаг.

Түүнээс гадна сувьдаг шунахай сэтгэлээсээ болж бие, хэл, сэтгэлээр нүгэл үйлдэнэ. ХҮН Энэ ертөнцөд зовж, үхсэнийхээ дараа нөгөө ертөнцөд очихдоо харанхуй тамын элдэв зовлонг эдэлдэг.

6. Сувьдаг шунахай сэтгэл бол ертөнцийн хамгийн хэцүү шунал тачаал бөгөөд бусад нь түүний эрхэнд байдаг.

Хомхой сэтгэл нь хорвоогийн шунал тачаал соёолж ургадаг чийгтэй хөрс лүгээ адил юм. Энэхүү ховдог сэтгэл нь хорвоогийн элдэв шунал тачаалыг төрүүлнэ. Сувьдаг шунахай сэтгэл бол буяныг залгидаг шулмас юм. Хомхой сэтгэл ямар ч буяныг үгүй болгоно.

Ховдог хомхой сэтгэл бол цэцгийн сүүдэрт нуугдаж буй хорт могой лугаа адил бөгөөд хүслийн

Нисваанис

цэцэгт хуруу хүрсэн болгоныг хөнөөх амой. Ховдог хомхой сэтгэл бол мод ороож ургадаг хорт ургамал бөгөөд хүний сэтгэлийг ороож, буяных нь шим шүүсийг сордог юм. Ховдог хомхой сэтгэл бол шуламын шидсэн талх, түүнийг авсан хүн нүглийн замаар ордог.

Хэрэв өлсгөлөн нохойд цус түрхсэн хоосон булуу хаяж өгвөл шуналтай нь аргагүй түүнийг мэрэх боловч дэмий л цуцаж, зовж зүдэрнэ.

Хэрчим махны төлөө зэрлэг амьтад нэг нэгэнтэйгээ уралцдаг. Асаасан бамбар бариад салхи сөрөн явж буй мунхаг хүн бамбарынхаа галд шатна. Зэрлэг амьтад, мунхаг хүмүүс сувьдаг шунахай сэтгэлээсээ болж өөрсдийгөө зовоож эсвэл шатаадаг.

7. Хорт сум гаднаас эрчлэн нисч ирвэл түүнээс хамгаалж болно, хэрэв дотроос эрчлэн нисч ирвэл хамгаалж үл болно. Шунал хүсэл, уур хилэн, харанхуй мунхаг, ихэмсэг зан энэ дөрвийг элдэв өвчин халдаадаг хорт дөрвөн сумтай зүйрлэж болно.

Сэтгэлд шунал хүсэл, уур уцаар, мунхаг ухаан үүрлэсэн цагт хүн худал ярьж, илүү дутуу чалчиж, хараал хэлж, хоёр нүүр гаргаж, амьтан алж, хулгай хийж, буруу хурьцах бүлгээ.

Сэтгэлээр үйлдэх гурав хэл амаар үйлдэх дөрөв, биеэр үйлдэх гурван нүглийг арван хар нүгэл гэнэ.

Хэрэв хүн санаатай худал хэлж эхэлвэл ямар ч муу үйл үйлдэнэ. Буруу хэрэг хийж буй учир худлаа ярихаас өөр аргагүй болдог. Худлаа ярьдаг учраас нүгэл үйлдэхдээ ичиж зовохыг мэдэхгүй.

Ховдоглох, шунаж хүсэх, айж эмээх, уурлаж уцаарлах нь цугаараа мунхаг ухаанаас үүднэ. Мөн гай гамшиг, аюул зовлон ч мунхаг ухаанаас урган гардаг. Энэ ертөнцөд мунхаг ухаан элдэв халдварын эх булаг мөн.

8. Хүн хорвоогийн шунал тачаалд автаж муу үйл үйлдэнэ. Муу муухай үйлсээсээ зовж шаналдаг. Хорвоогийн шунал тачаал, муу үйл, зовлон зүдүүр нь эцэсгүй эргэлдэж байдаг гурван хүрд юм.

Эдгээр хүрдний эргэлт нь эхлэл, төгсгөлгүй юм. Хүн энэ хүрээнээс гарч үл чадна. Энэ хүрээнд эргэлдэж, дахин дахин төрж, энэ ертөнцөөс өөр ертөнцөд шилжин очиж, тэндээсээ гурав дахь ертөнцөд шилжиж, ийнхүү дуусашгүй олон төрлийг олно.

Энэхүү мөнхийн эргэлдэх хүрээнд хүний үхсэн

Нисваанис

болгоных нь дараа шатаасан ясыг нь цуглуулбал Сүмбэр уулнаас өндөр болно. Энэ цаг хугацаанд ээжээсээ хөхсөн сүүг цуглуулбал сүн далайгаас илүү болно.

II

ХҮНИЙ ЗАН АРАНШИН

1. Хүний зан чанарыг таних хэцүү. Үлгэрлэвэл, хаагуур нь ч орохын аргагүй битүү ургасан зэгс лүгээ адил билээ. Хүнийхийг бодвол зэрлэг амьтны зан чанарыг танихад хялбар юм. Зан чанарынх нь хувьд хүмүүсийг дөрвөн зэрэгт хувааж болно.

Нэгдүгээрт, зовж шаналж буй хүмүүс багтана. Тэд буруу сургаалыг дагаж бие бялдраа зовоож тарчлаадаг.

Хоёрдугаарт, бусдыг зовоож буй хүмүүс орно. Тэд, амьд амьтныг алж талах, хулгай хийх зэрэг олон

муу үйлийг үйлддэг.

Гуравдугаарт, өөрсдөө зовж, бусдыг зовоодог хүмүүс багтана.

Дөрөвдүгээрт, өөрөө үл зовж, бусдыг үл зовоодог хүмүүс багтана. Тэд энх тайван, амар амгалан байдалд, аливаа хүсэл шуналаас ангид амьдарна. Бурхан багшийн сургаалын дагуу тэд амьтан үл алж, сайн үйлс бүтээнэ.

2. Түүнээс гадна энэ ертөнцөд гурван төрлийн хүмүүс буй. Чулуун дээр сийлсэн бичиг лүгээ адил, элсэн дээр зурсан бичиг лүгээ адил, усан дээр бичсэн бичиг лүгээ адил хүмүүс болой.

Чулуун дээр сийлсэн бичиг лүгээ адил хүмүүс уурлаж уцаарлах нь олонтаа, тэр нь удаан үргэлжилж, чулуун дээр сийлсэн бичиг лүгээ адил мөд арилахгүй.

Элсэн дээр зурсан бичээс лүгээ адил хүмүүс уурлаж уцаарлах нь их боловч уур хилэн нь түргэн арилж, зүйрлэвээс элсэн дээрх бичээс лүгээ адил замхармуй.

Усан дээр бичсэн бичээс лүгээ адил хүмүүс усан дээр бичмэгц урсан арилах бичээс лүгээ адил; тэд

Нисваанис

бусдыг муучилдаггүй, муу муухай юмны тухай сонсоод хэрэгсдэггүй бөгөөд санаа сэтгэлд нь ямагт энх тайван, амар амгалан ноёрхож байдаг.

Мөн өөр гурван зүйлийн хүмүүс буй. Эхнийх нь ааш зан эгэл жирийн, сэтгэл хөдөлж үймрэх нь амархан, хөнгөмсөгдүү, ямагт хувирамтгай, удаах нь зан чанарын хувьд амаргүй, дуу шуу цөөнтэй, төлөв даруу, маш болгоомжтой, сэтгэлээ барьж хүслээ удирдаж чадах бүлгээ. Түүний удаах нь бүр ч амаргүй, тэд хорвоогийн шунал тачаалаа үндсээр нь дарж устгасан байдаг.

Энэ ертөнцөд олон янзын хүн буй тул, хүн болгоны зан чанарыг ойлгож танихад бэрх хэцүү, гагцхүү Бурхан багш тэдний зан чанарыг ойлгож, хүн болгоныг түүнийх нь дагуу сургаж чадна.

Ш ХҮНИЙ АМЬДРАЛ

1. Нэгэн хүний амьдралын тухай сургаал домогт өгүүлснээр, тэрбээр завинд сууж голын урсгал даган хөвж явахад эрэг дээр буй өөр хүн түүнд хандан хашгирсан нь: “Урсгал дагаж баяр баясгалантай уруудаж байна уу. Гэхдээ чи сайн бод. Урсгал дагавал өндөр өндөр давалгаа, эргүүлэг бий, матар,

догшин шуламууд бтхий ёроолгүй ус бий. Тэнд чи

Энэ домогт урсаж буй гол ус нь зугаа цэнгэлд автсаар өнгөрөх амьдралыг төлөөлнө. "Урсгал дагаж баяр баясгалантай" уруудах гэдэг нь өөртөө дасахын нэр юм. "Өндөр өндөр давалгаа" нь уур уцаар, зовлон зүдүүр, "Эргүүлэг" нь зугаа цэнгэл юм. "Матар, догшин шуламууд бүхий ёроолгүй ус" нь нүгэл үйлдэж доройтохыг төлөөлнө. "Эрэг дээр буй хүн" нь Бурхан багш юм.

Өөр нэг домог үлгэр сонсоно уу. Нэг хүн гэмт хэрэг үйлдчихээд зугтжээ. Араас нь хүмүүс нэхэн элдэж, гүйцэж очоод тал талаас нь бүсэлж, ухран зугтах замгүй болгов. Хавханд орсон лугаа адил болсон тэр хүн дэргэд нь ашиглахаа больсон худаг буйг гэнэт олж харжээ. Худгийн хашлагаас ороонго мод доошоо унжиж байлаа. Тэрбээр ороонго модоор доошоо бууж эхлэв. Тэгтэл худагны ёроолд хорт могой өөрийг нь бууж ирэхийг хүлээж буйг харсан аж. Тэрбээр доошоо буухаа больж ороонго модны тэг дунд гацчихав. Удалгүй гар нь чилжээ Хажуугаар нь тас хар, цав цагаан хоёр хулгана ороонго модыг мэргэж эхлэв.

Хулгана ороонго модыг мэргэж дуусмагц тэр хүн доошоо унаж, могойн идэш болно. Тэрбээр толгойгоо дээш өргөтөл зөгийний үүрнээс ам руу нь

Нисваанис

амтат балны хэдэн дусал унав. Тэрбээр балыг амталж аюулд орсноо ч умартав.

Энэхүү домог үлгэрт "Нэг" гэдэг нь эл ертөнцөд эхлээд төрдөг, дараа нь үхдэг хүний ганцаардлыг илэрхийлж байгаа юм. "Араас нь хүмүүс нэхэн элдэх", "Хорт могой" хэмээх нь янз янзын хүслийн эх булаг болсон бие юм. "Ашиглахаа больсон худагт ургасан ороонго" нь хүний амьдрал гэсэн үг билээ. "Хар, цагаан хоёр хулгана" хэмээх нь цаг хугацаа юм. "Амтат зөгийн балны дусал" бол зугаа цэнгэл юм.

2. Дахин нэг домог үлгэрийг сонсмуу. Хаан хайрцганд дөрвөн хорт могой хийж, асарч байхыг нэг хүнд тушааж, сануулсан нь: "Хэрэв ганцхан ч болов могойны уурыг хүргэвэл толгойгүй болно гэж мэдээрэй". Нөгөө хүн энэ тушаалаас үнхэлцгээ хагартал айж могойтой хайрцгийг хаяж зугтаав. Үүнийг мэдсэн хаан бариулахаар араас нь таван зарцаа явуулжээ. Тэд зугтсан хүнийг мэхлэн хаанд авчрахыг төлөвлөсөн ч, цаадах нь мэхэнд оролгүй улам цааш зугтааж, нэг тосгонд хүрээд тэнд орогнох байр хайж эхлэв.

Гэтэл тэнгэрээс нэгэн дуу дуулдаж, энэ тосгонд хэн ч үл амьдрах бөгөөд өнөө шөнө зургаан дээрэмчин ирнэ гэв. Айж сандарсан хүн цааш зугатав. Замд нь хүчтэй урсгал бүхий гол тааралджээ.

Гатлахад хэцүү байсан ч, энэ талын эрэг дээр үлдвэл аюултайг мэдэрсэн хүн сал зангидаж, арайчүү цаад эрэг дээр нь гарч анх удаа аюулгүй газар ирснээ мэдрэв.

Энэ домог үлгэрт "Хорт дөрвөн могой хийсэн хайрцаг" нь газар, ус, гал, салхи хэмээх дөрвөн махбодоос бүрдсэн хүний биеийг төлөөлнө. Энэхүү бие хүслийн эх булаг, санаа сэтгэлийн дайсан мөн билээ. Тиймээс тэр хүн ийм биенээс зугатахаар шийдсэн аж. "Таван зарц зугтсан хүнийг мэхлэхээр шийдсэн" гэдэг нь хүний бие, түүний сэтгэлийг бүрдүүлсэн таван махбодын нэр юм.

"Орогнох байр" нь хүний зургаан мэдрэхүй, "Зургаан дээрэмчин" бол зургаан, мэдрэхүйн тусагдахуун билээ. Мэдрэхүйн эрхтнүүд аюул авчирдагийг ухаарсан хүн улам цаашаа зугтахад зам хаасан "Түргэн урсгалтай гол" бол хорвоогийн шунал тачаалд автсан амьдрал буюу.

Бурхан багшийн сургаалын салыг зангидсан хүн хорвоогийн шунал тачаалын аймшигтай, гүн гүнзгий голыг гэтэлж, цаад эрэгт гарч амар тайван, энх амгалан байдлыг олсон аж.

3. Энэ хорвоод эх нь хүүхдээ, хүүхэд нь эхээ аварч чадахгүй гурван тохиолдол буй. Эдгээр нь их

Нисваанис

түймэр, их үер, их дээрэм болой. Гэвч ийм тохиолдолд хүртэл заримдаа эх, үрс бие биедээ тус болж чадна.

Харин эх нь үрдээ, үр нь эхдээ яагаад ч тусалж чадахгүй өөр гурван тохиолдол байдаг. Үүнд өтлөх, өвдөх, үхэхээс, айх энэ гурван тохиолдол орно.

Эх нь өтөлж буйг харсан хүүхэд өөрийн биеэр өтөлж буй эхээ орлож чадах уу? Өвдөж буй хүүхдийнхээ дэргэд уйлж суугаа эх нь өөрийн биеэр өвдсөн хүүхдээ орлож чадах уу? Хүүхэд нь, эсвэл эх нь үхэж байхад хэдийгээр энэ хоёр эх, үрийн холбоотой ч гэсэн хэрхэн өөрийн биеэр нэг нь нөгөөгөө орлон нөхөж чадах билээ. Эх үрс бие биедээ хязгааргүй хайртай ч эдгээр тохиолдолд нэгэндээ яагаад ч тус болж чадахгүй.

4. Энэ ертөнцөд олон муу үйл үйлдсэн хорон санаат хүн үхсэнийхээ дараа тамд унахад Тамын эзэн Эрлэг хаан түүнээс: "Чи хүний ертөнцөд байхдаа гурван сахиулсан тэнгэртэй учирсан уу?" гэхэд: "Үгүй ээ, би сахиулсан тэнгэртэй учраагүй" гэв.

"Тэгвэл чи таяг тулж бөгтийсөн, арай ядан хөлөө зөөсөн хөгшчүүлтэй уулзаж байсан уу?" хэмээв. "Тийм ээ, би тийм олон өвгөнтэй учирч байсан" гэв. "Чи тэдгээр сахиулсан тэнгэртэй учирсан ч тэдэнтэй адил өтлөхөө эс ойлгож, сайн үйл яаран бүтээхийг

бодсонгүй. Тиймээс одоо ийм шийтгэлийг хүлээж байгаа юм" гэв.

"Чи хэвтэрт орсон, харахад нүд дальдирмаар турж сульдсан өвчтэй хүмүүстэй учирч явсан уу?". "Би тийм өвчтөнтэй олон удаа таарч байсан". "Чи өвдөж" буй сахиулсан тэнгэртэй учрахдаа өөрийг чинь бас өвчин ороохыг ойлгосонгүй. Тиймээс тамд унасан байна".

"Чи дэргэдээ үхэж буй хүмүүсийг харсан уу?" "Би үхэж буй хүмүүстэй олонтаа таарсан". "Амьд бүхэнд үхлийг сануулагч сахиулсан тэнгэртэй учирсан боловч чи, хэзээ нэгэн цагт өөрөө үхэхээ эс ухаарч, сайн үйл бүтээхийг бодсонгүй. Тиймээс ч ийм шийтгэл амсаж байгаа юм. Хийсэн үйлийнхээ үрийг өөрийн биеэр амсах ёстой".

5. Нэгэн баян хүний бэр Кисаготами ганц бяцхан хүүгээ алджээ. Зовлон гасланд нэрвэгдсэн залуухан эхийн ухаан санаа элий балай болжээ. Тэрбээр хүүгийнхээ хөрсөн цогцсыг элгэндээ нааж, хайртай хүүгий нь эдгээж чадах хүнийг олохоор явжээ.

Тааралдсан хүмүүс зовлонг нь хуваалцах боловч нэг нь ч тусалж эс чадна. Ялж төгс нөгчсөн багшийн нэг шавь нь эмэгтэйг өрөвдөж Жетаванад буй багш дээрээ очихыг зөвлөсөн аж. Залуухан эх

Нисваанис

хүүгээ тэвэрсээр Бүхнийг айлдагч багш руу яарчээ.

Хамгийг мэдэгч багш, эмэгтэй рүү анхааралтайяа ширтэн хараад хэлсэн нь: "Эмэгтэй минь, хүүхдийг чинь эмчилж эдгээхийн тулд намуу цэцгийн үр хэрэгтэй. Хотод очоод хүнээс 4-5 ширхэг үр гуйгаад ир. Гэхдээ нэг ч хүн нь талийгаач болоогүй тийм айлаас авсан намуу цэцгийн үр байх ёстой" гэв.

Уй гашууд автаж, ухаан санаа нь балартсан эх намуу цэцгийн үр олж авчрахаар хот руу явжээ. Тэрбээр намуу цэцгийг амархан олсон боловч, нэг ч хүнээ алдаагүй айл өрхийг олсонгүй. Эмэгтэй өөрт нь хэрэгтэй намуу цэцгийн үрийг олж чадалгүй, Бурхан багш дээр буцаж очжээ. Амарлингуй оршигч багш амар амгалан байдалд, дуу чимээ үл гарган суухыг хараад эмэгтэй сая Түүний үгийг утгыг ойлгожээ. Тэрбээр нойроос сэрсэн юм шиг болж, ухаан санаа нь эрүүл саруул болов. Чингээд хүүхдийнхээ хүйтэн цогцсыг оршуулж, Чадагчийн эрхт багш дээр эргэж ирээд Түүнд шавь оржээ.

IV

ХҮНИЙ БОДИТ АМЬДРАЛ

1. Энэ дэлхийд амьдарч буй хүмүүс нэг нэгийгээ хайхардаггүй, нэг нэгийгээ хайрладаггүй билээ. Тэд

өчүүхэн юмнаас хэрэлдэж, нүгэл хилэнц зовлон зүдүүр дунд амьдарч, амьдрал нь тэр чигээрээ гай гамшиг, зовлон зүдүүрийн битүү тойрог болном.

Тэд байр суурь, эд баялгаасаа үл шалтгаалан зөвхөн мөнгөний тухай бодож зовж шанална. Нэг хэсэг нь мөнгөгүй болоод зовно. Нөгөө хэсэг нь мөнгөтэй болоод зовно. Тэд, гагцхүү хүслээ хангахыг л бодож, нэг хором ч амар тайван байж чаддаггүй.

Баян хүмүүс тариалангийн талбайтай бол түүнийхээ төлөө, байшинтай бол бас түүнийхээ төлөө санаа зовно. Тэд өөрт нь буй, дасаж дадсан бүх юмныхаа төлөө санаа зовж байдаг. Гай тохиолдож, саад бэрхшээл учрах, эсвэл эд баялаг нь түймэрт шатахад зовон шаналж, түүгээр ч зогсохгүй амиа хорлох гэнэ. Тэр ч бүү хэл тэд үхлийн замд ганц ганцаараа одож, тэднийг хэн ч үл дагалдана.

Ядуу нь юу ч үгүй хоосноосоо болж зовж зүдэрдэг. Тэд байшин сав, тариалангийн талбайтай болохыг хүснэ. Тэд хүслийн галд шатаж, бие сэтгэлээрээ ядарч сульдана. Үүнээс болж тэд олдсон амьдралаа бүрэн гүйцэд эдэлж чадалгүй цагаасаа өмнө амьсгал хураана. Тэдэнд энэ хорвоогийн бүх юм дайсагнах шиг санагддаг бүлгээ. Үхлийн урт замд тэд мөн л нэг нэгээрээ оддог.

Нисваанис

2. Энэ ертөнцөд таван нүгэл буй. Нэгдүгээрт, хүн болоод газар дээр мөлхөгч амьтан хүртэл бие биедээ байнга дайсагнаж байдаг. Хүчтэй чадалтай нь сул доройгоо шахан хавчиж, сул дорой нь хүчтэй чадалтайгаа хууран мэхэлнэ. Тэд хоорондоо дайсагналцаж, нэг нэгийгээ үргэлж гомдоож, доромжилж байдаг.

Хоёрдугаарт, эцэг эх, үр хүүхэд, ах дүү нар, эхнэр нөхөр, төрөл төрөгсөд, ойр дотны хүмүүс өөрийн гэсэн амьдралын зарчимгүй, хатуу чанд дүрэм журамгүй байдаг. Тэд гагцхүү амиа бодож, хүслээ хангахыг хичээнэ. Тэдэнд өөрийн үнэн үгүй. Тэд бие биенээ хууран мэхэлж, үг үйл хоёр нь үргэлж зөрнө.

Гуравдугаарт, бүх амьтан атгаг муу санаа өвөрлөж, шунал тачаалд автдаг. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль нь ч ноогдсон үүргээ биелүүлдэггүй. Учир иймээс хоорондоо дайсагнаж, хэсэг бүлэг болон хуваагдаж, хорт үйл үйлддэг.

Дөрөвдүгээрт, хэн ч сайн үйл бүтээхийг эрмэлздэггүй. Бие биеэ муу уруу татаж, муу үйл үйлдэж, худал ярьж, дэмий чалчиж, бусдыг муучилж, хоёр нүүр гаргаж, нэг нэгийгээ доромжилно. Бие биесээ үл хүндлэх тул, хүн бүр өөрийгөө энэ хорвоогийн хамгийн чухал хүн хэмээн үзэж, өрөөлийг доромжилсондоо огтхон ч ичиж

гэмшихгүй.

Тавдугаарт, бүх хүн залхуу хойрго зантай, сайн үйл бүтээхийг үл мэднэ. Тэд баярлаж талархахыг мэдэхгүй, үүргээ ухамсарлахгүй. Гагцхүү өөрийн хүсэлд хөтлөгдөж, бусдад гай тарьж, эцсийн эцэст хүнд гэмт хэрэг үйлдэнэ.

3. Хүмүүс бие биенээ хүндэтгэж , нэг нэгэндээ тус болох ёстой. Гэтэл тэгэхийн оронд хувийн өчүүхэн ашиг сонирхлоо дээдэлж, биесийг үзэн ядна. Ингэхдээ бяцхан маргаан нь яваандаа томоохон хэрүүл дэгдээж, гүн их нуугдмал хонзон, гомдож өших сэтгэл төрүүлдгийг үл мэднэ.

Хэдийгээр энэ ертөнцөд дайсагнах нь хоёр талд хоёуланд нь хор хүргэх боловч шууд сүйрэлд авчирдаггүй. Гэвч тэр нь сэтгэлийг хордуулж, хүнийг уур уцаартай болгож, сэтгэл санааг нь хувирган өөрчилдөг. Иймээс хүмүүс дахин дахин төрж, бие биеэ доромжилж, гүжирдэн гүтгэж, өвөр зуураа дайсагналцсаар байгаа юм.

Энэхүү ховдог хомхой сэтгэл, шунал тачаалын ертөнцөд хүн ганцаараа төрж, ганцаараа үхдэг. Үйлийн үрийг нь ирээдүйд өөр хэн ч бус, өөрөө л үүрэх ёстой болдог.

Нисваанис

Буян, нүгэлийн хариу өөр өөр буй. Буян үйлдсэн хүн зол жаргалыг олдог бол, нүглийн хариуд гай гамшиг ирдэг. Энэ бол хөдөлшгүй үнэн юм. Гэхдээ хүн бүр үйлдсэн үйлийнхээ хариуг заавал өөрөө амсана.

4. Хүсэл шунал, дадал заншил, зовлон зүдүүрээр бат бэх холбогдсон хүмүүс цаг хугацаа улиран өнгөрөхөд улам цөхөрч зовно. Тэд гүн гүнзгий цөхрөлд автаж, ховдог хомхой сэтгэлээ хангахыг хичээж, уур омогтой болж, эрүүл ухаанд багтамгүй юм үйлдэж, хэрэлдэж, зөв зам мөрийг үл олж, цагаасаа өмнө үхэж, байнга шаналж зовохоос өөр аргагүй болдог.

Хүмүүсийн иймэрхүү амьдрал байгалийн хуулинд ч тэр, газар, тэнгэрийн хуулинд ч тэр үл нийцнэ. Ийм амьдрал гай гамшиг л авчирч, хүмүүс энэ ертөнц болон хойт насандаа ч заавал зовж зүдэрнэ.

Үнэхээр энэ хорвоод бүх юм урсан улирч, түргэн өөрчлөгдөж, тогтвортой, найдлагатай юу ч байхгүй бүлгээ. Ийм нөхцөлд байгаа хэрнээ бүгд л зугаа цэнгэл хөөцөлдөх нь ихэд гунигтай юм.

5. Энэ бол ертөнцийн үнэн дүр зураг юм. Энэ ертөнцөд хүмүүс зовлон дунд төрж, сайн үйлсийн тухай өчүүхэн бээр үл мэдэж, гагцхүү нүгэл үйлдэнэ.

Тиймээс хорвоогийн жам ёсны дагуу улам их зовлон эдэлнэ.

Хүмүүс гагцхүү хувиа хичээж бусдад үл тусална. Тэд хүслийнхээ хүлээсийг сул задгай тавьж, шунал тачаалын галыг бадрааж, зовж зүдэрч, хариуд нь улам их тарчлан шаналдаг.

Цэцэглэж дэгжих нь удаан үл үргэлжилж, нүд ирмэх зуур улиран одно. Энэ ертөнцөд зугаа цэнгэл мөн адил дорхноо арилан өнгөрнө.

6. Тиймээс хүн хорвоогийн явдлаас салж, эрүүл саруул байгаа дээрээ зөв замд орж, мөнхийн амьдралыг хүсэх хэрэгтэй. Зөв зам мөрөөс өөр илүү аятай, тааламжтай юм буй гэж үү?

Гэвч хүмүүсийн сайн үйлийн ачаар буян хураадаг, зөв үйл хэрэг зөв зам мөрд хөтөлж авчирдагт үл итгэнэ. Тэд, хүн үхсэнийхээ дараа дахин төрөхийг ч үл мэднэ. Бусдад туслах бол жаргал гэдэгт тэд үл итгэнэ. Тэд буян, нүгэлтэй холбоотой юунд ч үл итгэнэ.

Хүмүүс алдаж, зөв сургаал, сайн үйл юу болохыг үл мэднэ. Тэдний санаа сэтгэлд харанхуй ноёрхож, үйл хэрэг нь бүтэх, эс бүтэх болон зол жаргал тохиолдох, золгүй явдал учрахын хууль журмыг үл

Нисваанис

мэднэ. Тэд гагцхүү уйлж унжиж, энэ амьдралдаа гуньж гутарна

Ертөнцөд мөнхийн юм үгүй, бүх юм улиран урсаж, хувиран өөрчлөгдөж байдаг. Үүнээс болж хүмүүс уйтгарлан гуньж, зовж зүдрэхээс өөр юу ч мэдэхгүй. Зөв сургаалыг үл сонсож, гүн гүнзгий бодож бясалгадаггүй. Тэд амархан олдлогоор нь гагцхүү зугаа цэнгэл эргүүлнэ. Тэдний эд баялагтай болох эрмэлзэл, шунал тачаалд нь эцэс төгсгөл, зах хязгаар үгүй.

7. Аль дивангараас эхлэн хүмүүс төөрөгдлийн ертөнцөд амьдарч, мөнхийн түгшүүрт оршиж, хязгааргүй их зүдэрдэг. Энэ төөрөгдөл эдүгээ үргэлжилсэн хэвээрээ юм. Харин одоо тэд Бурхан багшийн сургаалыг мэдэх, Түүнд итгэх боломжтой болсон нь юутай сайхан бэ.

Тэд гүн гүнзгий бодлогоширч, нүглээс холдож, буяныг сонгож, Бурхан багшийн сургаалыг дагах ёстой.

Аз болоход одоо цугаараа Бурхан багшийн сургаалыг танин мэдэх бололцоотой учир Түүнд сүсэглэж, Бурхан багшийн ертөнцөд мэндлэхийг хүсч байх ёстой. Бурхан багшийн сургаалтай танилцсаны дараа бусдад уруу татагдаж, хорвоогийн

шунал тачаалын эрхэнд орж, нүгэл үйлдэхийг тэвчих хэрэгтэй. Зөвхөн өөртөө авралыг хүсч болохгүй, харин энэ сургаалыг түгээн дэлгэрүүлж, бусад хүмүүст ч авралыг ерөөх хэрэгтэй.

V БӨЛӨГ
БУРХАН БАГШИЙН АВРАЛ
I
БУРХАН БАГШИЙН ТАНГАРАГ

1. Хүмүүст хорвоогийн шунал тачаалаас салж ангижрах туйлаас хэцүү. Эрт дээр үеэс тэд муу үйл үйлдэж, төөрөлдөж буй билээ. Тиймээс ч тэд Бурхан багшийн мөн чанартай боловч, түүнийгээ илрүүлэн гаргаж үл чадна.

Хүний зан чанарыг сайн мэддэг Бурхан багш аль дивангарын үеэс бодьсад болохоор шийдэж, Дээд зэргийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэлийг үзүүлэн хүмүүсийг айж эмээх, зовж зүдрэхээс ангижруулж эхэлсэн юм. Үүний тулд Тэрбээр олон тангараг өргөж, өөрт нь ямар ч хүнд сорил тохиолдсон бололцоотой бүхнийг хийхээ андгайлж:

а) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний ертөнцөд төрж буй хүмүүс Бурханы хутгийг олж чадахгүй буюу гэгээрэхгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

б) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний гэрэл гэгээ хязгаарлагдмал, ертөнцийн өнцөг булан бүрт хүрэхгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

в) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний амьдрал хязгаарлагдмал, тодорхой он жилд багтахаар байвал би өөрөө гэгээрэхгүй;

г) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, ертөнцийн бүх арван зүгийн орны бурхад миний нэрийг магтан дуулж алдаршуулахгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

д) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс миний сургаалд гүн гүнзгий итгэн сүсэглэж, миний ертөнцөд мэндлэхийг хүсч, миний нэрийг амандаа арав давтавч тэгж чадахгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

е) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний сургаалыг дагахаар шийдсэн ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс олон буяныг үйлдэж миний ертөнцөд мэндлэхийг чин сэтгэлээсээ хүсээд үхэхэд нь, би агуу их бодьсад нарын хамт тэдний өмнө тодрон гарч ирэхгүй бол өөрөө гэгээрэхгүй.

ж) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс миний тухай танин мэдээд, миний ертөнцийн тухай мөрөөдөж, тэнд мэндлэхийг чин зүрхнээсээ хүсэн буяны үрийг таривч тэгж чадахгүй байвал би өөрөө гэгээрэхгүй;

Бурхан Багшийн Аврал

з) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний ертөнцөд төрөл олсон хэн ч гэсэн Бурхан багш болж бусад хүмүүсийг сургаж, тэднийг гэгээрэл, Их нигүүлсэнгүй сэтгэлийн буян руу залж чадахгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

и) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний гэрэл гэгээ гийсэн ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс бие сэтгэлээрээ эс тайвширч, энэ ертөнцөд бусдаас илүү болохын хүслээр бадрахгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

к) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс намайг таньж мэдээд амьдрал, үхлийн тухай нарийн үнэнийг эс ухаарч, гүн их оюун ухааныг эс олвол би өөрөө гэгээрэхгүй.

Би эдгээр тангаргыг өргөж байна. Хэрэв миний энэ бүх хүсэл эс биелвээс би өөрөө гэгээрэхгүй. Би бээр шавхагдашгүй гэрэл гэгээний эх булаг болж, бүх орныг гийгүүлэн гэрэлтүүлж хүмүүсийг төөрөгдлөөс ангижруулж, хүмүүст сургаалын санг нээж, газар сайгүй буяныг үйлдэх болно.

2. Бурхан багш эдгээр тангаргыг өргөөд, урт удаан хугацаанд хязгааргүй их буяныг үйлдэж Өөрийн Ариун цагаан ертөнцийг бүтээж, аль дивангарт

Бурхан багш болоод, одоо Өөрийн сургаалыг Өөрийн Ариун гэгээн оронд заан номлож байна.

Энэхүү ариун цагаан ертөнцөд цэвэр ариун, амар амгалан байдал ноёрхож байдаг юм. Энд төөрөгдөл үгүй, гагцхүү гэгээрэхийн баяр баясгалан буй. Хувцас хунар, хоол хүнс, аливаа гоо сайхан юмс энэхүү ертөнцийн оршин суугчдын хүслээр буй болдог. Ариухан салхи намуухан сэвэлзэж, эрдэнэсийн моддыг үл мэдэг ганхуулахад гэгээн сургаалыг номлогч дуу хоолой агаар мандлыг дүүргэж, сонсож буй бүгдийн сэтгэлийг ариутгана.

Энэ ертөнцөд өнгө бүрийн тансаг анхилуун үнэртэй лянхуа цэцэглэж байдаг. Цэцэг болгон өөр өөрийн гэрэл гэгээг сацруулах хязгааргүй олон дэлбээтэй юм. Гэрэл болгон Бурхан багшийн оюун ухааныг номлож, анирхан сонсогч бүгдийг энх тайван, амар амгалан бүхий Бурхан багшийн зам мөрөөр зална.

3. Бүх арван зүгийн орны Бурхан багш нар энэхүү Бурхан багшийн буяныг магтан дуулна.

Энэхүү Бурхан багшийг мэдсэн хэн боловч Түүнд баяр баясгалантайгаар итгэвэл Түүний ертөнцөд мэндэлнэ.

Бурхан Багшийн Аврал

Энэхүү Бурхан багшийн ертөнцөд очсон хэн боловч мөнх насыг олж, бусад хүмүүсийг аврахын хүслээр бадарч, энэхүү ариун үйл хэрэгт өөрийгөө буй чигээр нь зориулмуй.

Тэд ийм хүслээр шатан бадарч, дасаж дадсанаасаа ангижиран, ХҮНИЙ оршихын мөнх бусыг танин мэднэ. Тэд зөвхөн өөртөө бус, бусдад тустай үйлийг эхэлж, бусдын итгэл найдвар, зовлон зүдүүрийг хуваалцана. Тэд хорвоогийн амьдралын аливаа хүлээс, дадал заншлаас чөлөөтэй буюу.

Тэд энэхүү ертөнц зовлон зүдүүрээр дүүрнийг мэдэх бүлгээ. Тэд Бурхан багшийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэл эцэс төгсгөлгүй, зах хязгааргүйг сайн мэднэ. Тэдний санаа сэтгэлд аливаа дадал заншил байхгүй. Тэд өөрийгөө бусдаас, бусдыг өөрөөсөө өчүүхэн бээр үл ялгадаг. Тэд төгс эрх чөлөөтэй билээ. Тэд хаашаа л бол хаашаа явж, урагшаа ч тэр, арагшаа ч тэр хөдөлж чадах боловч Бурхан багшийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэлийг хүртэх ёстой хүмүүсийн хамт үлдэх нь дээр гэж үздэг.

Тиймээс Бурхан багшийг таньж мэдсэн хэн боловч Бурхан багшийн алдрыг ганц удаа ч гэсэн баяр баясгалантайгаар давтвал Бурхан багшийн ерөөлийг хүртэнэ. Бүх хүн Бурхан багшийн сургаалыг анхааралтайяа сонсч, амьдрах, үхэхийн ертөнцийг бүхэлд нь залгисан гал руу Тэрбээр дахин

дагуулан явж буй мэт санагдсан ч Түүнийг дагах хэрэгтэй.

Хэрэв Хүмүүс үнэхээр гэгээрэхийг хүсвэл Бурхан багшийн тусыг гуйх хэрэгтэй.

Бурхан багшийн туслалцаагүйгээр жирийн хүн гэгээрч чадахгүй.

4. Одоо ч Бурхан багш биднээс тун холгүй байгаа юм. Хэдийгээр Түүний ертөнц асар хол оршивч, Бурхан багш Өөрөө түүний тухай бодож буй бүх хүний сэтгэлд амьдарч байдаг.

Хэрэв сэтгэлд оршиж буй энэ Бурхан багшийн дүрийг төсөөлвөл Тэрбээр тоолж баршгүй алтан гэрэл туяагаа тал тал тийшээ түгээж, 84 мянган дүр төрхийг үзүүлнэ. Дүр, төрх бүр мянган туяаг цацруулна. Туяа бүр Бурхан багшийн тухай хэн бодно, түүнийг гэрэлтүүлж, хэзээ ч үл орших билээ.

Бурхан багшийг харж буй хүн Түүний сэтгэлийг үзнэ. Түүний сэтгэл нь дээд зэргийн энэрэнгүй болой. Тэрбээр Өөрт нь итгэж сүсэглэсэн бүхнийг авраад зогсохгүй, мөн Өөрийнх нь энэрэнгүй сэтгэлийг үл мэдэх, эсвэл Өөрийг нь мартсан хүмүүсийг ч аварна.

Бурхан багш Өөрт нь итгэн сүсэглэдэг хүнд Өөртэйгээ нийлэн нэгдэх бололцоо олгоно.Түүний тухай үргэлж бодвол Тэрбээр Өөрөөрөө аливаа юмыг

Бурхан Багшийн Аврал

дүүргэж чадах тул хүн болгоны сэтгэлд нэвтрэн орно.

Тиймээс хүн Бурхан багшийн тухай бодоход, санаа сэтгэл нь Бурхан багшийн тод томруун дүр төрхийг олж, улмаар өөрөө Бурхан багш болно.

Сүсэг бишрэл сайтай, зөв шударга явдалтай хүний сэтгэл нь Бурхан багшийн сэтгэл юм.

5. Бурхан багш олон дүр төрхтэй. Тэрбээр хэний ч өмнө тухайн хүн авьяас чадварынхаа дагуу Бурхан багшийг ухааран ойлгохтой нь дүйж тохирох дүрээр тодорно. Бурхан багш ертөнцийг тэр чигээр нь Өөрөөрөө дүүргэж, Тэрбээр эцэс төгсгөлгүй, зах хязгааргүй чанартай болой. Тэрбээр хүний ухаанд танигдашгүй бүлгээ. Бурхан багшийг сансар огторгуй, байгаль дэлхий, хүн болгоны аль алинаас нь олж харж болно.

Бурхан багшийн нэр алдрыг давтсан хүн бүхэн Түүнийг олж харж чадна. Тэрбээр уг хүндээр заавал хоёр бодьсадыг дагуулан ирнэ.

Бурхан багш бүхий л ертөнцөд орших боловч Түүнд итгэж сүсэглэдэг хүн л түүнийг олж харна.

Бурхан багшийн харьцангуй нэгэн дүртэй учирсан ч хүн зол жаргалыг олно. Тиймээс жинхэнэ Бурхан багштай учирвал улам их, үнэхээр хэмжээ

хязгааргүй жаргалыг олно.

6. Энэ Бурхан багшийн сэтгэл нь гагцхүү Дээд зэргийн энэрэнгүй нигүүлсэл, оюун ухаан учраас Бурхан багш ямар ч хүнийг аварна.

Хүн мунхгаасаа болж хүнд хэцүү гэмт хэрэг үйлдэж, санаа сэтгэлдээ ховдог хомхой, уур уцаарыг үржүүлж, атгаг муу санааг өвөрлөж, худал ярьж, илүү дутуу чалчиж, хараал урсгаж, хоёр нүүр гаргаж, амьтан алж, хулгай хийж, худалд автаж, өөрөөр хэлбэл арван хар нүглийг үйлдэж байдаг бөгөөд муу үйлээсээ болж ирээдүйд үүрд зовж зүдрэх ялыг авдаг.

Хүнийг амьсгал хурааж байхад сайн найз нь ирж хэлэх нь: "Өмнө чинь чамайг зовлон зүдүүр хүлээж байна. Одоо чи Бурхан багшийн тухай бодож ч чадахгүй байна. Тэгвэл чи ядахдаа Түүний нэрийг давт".

Хэрэв хүн сэтгэл санаагаа төвлөрүүлж Бурхан багшийн нэр алдрыг хэдэнтээ хэлбэл, давтах болгонд нэгэн томоохон нүгэл нь цайрч, улмаар эцэс төгсгөлгүй төөрөн хэсүүчлэхийн ертөнцөөс авраг дана.

Хэрэв хүн Бурхан багшийн нэрийг давтвал нүгэл нь арилж эцэс төгсгөлгүй төөрөн хэсүүчлэхийн ертөнцөөс аврагдана. Хэрэв тэрбээр чин сэтгэлээсээ залбирвал бүр ч амархан бүтнэ.

Бурхан Багшийн Аврал

Үнэхээр Бурхан багшид мөргөн залбирч буй хүн цагаан лянхуа адил сайхан бүлгээ. Энэрэнгүй сэтгэл, оюун ухаан хэмээх хоёр бодьсад, тэр хүнд газарчилж зөв зам мөрөөр залж, Бурхан багшийн ертөнцөд авчирна.

Тиймээс бүх хүн "Наму-Амида бицу" буюу "Аминдава нэрт Цаглашгүй гэрэлт бурханд мөргөмүй" гэсэн үгсийг цээжлэх ёстой юм. Эдгээрийг тогтоох нь Бурхан багшийн нэрийг цээжилнэ гэсэн үг.

II

ЖАРГАЛЫН ОРОН

1. Бурхан багш үнэхээр оршиж Номоо номлож буй. Түүний ертөнцөд амьдарч буй хүмүүс зовж зүдрэхийг үл мэдэж, өдөр хоногийг жаргал цэнгэл дунд өнгөрөөнө. Тиймээс ч энэ ертөнцийг энхжингийн орон гэдэг.

Энэ ертөнцөд эрдэнийн чулуугаар бүтээсэн долоон нуур байдаг. Нуурын ус цэвэр тунгалаг. Нуурын ёроол алтан элсээр хучаастай. Нуурын усны мандал дээр том том лянхуа цэцэг ургана. Цэнхэр өнгийн лянхуа цэцэг цэнхэр гэрэл, шар өнгийн лянхуа цэцэг шар гэрэл, улаан өнгийн лянхуа цэцэг улаан гэрэл, цагаан өнгийн лянхуа цэцэг цагаан гэрэл тус тус цацраана. Тэдгээр нь эргэн тойрон ариун

тунгалаг, тансаг сайхан үнэр түгээнэ.

Нуурын дэргэд тус тусдаа алт, мөнгө, индранил, болороор бүтсэн дөрвөн ордон байдаг. Тэдгээр ордны нуурын эрэг рүү буусан шатыг гантигаар бүтээжээ. Зарим газар нуурын эрэг дээр эрдэнийн чулуун шигтгээ хэлхэж оёсон хөшгөөр хучаатай, гоё чамин хийцтэй хашаа хашлага босгосон үзэгдэнэ. Тэдгээрийн хооронд газар сайгүй тансаг сайхан үнэртэй мод, цэцэг ургана.

Дээд тэнгэрээс гайхамшигтай сайхан хөгжмийн эгшиг сонсдож, газар дэлхий алтан гэрлээр гэрэлтэнэ. Хоногт зургаан удаа тэнгэрээс цэцэг унана. Хүмүүс эдгээр цэцгийг түүж вааранд суулгаж, бусад бурхан багшийн ертөнцөд аваачиж, түм түмэн бурхан багш нарт өргөл болгоно.

2. Энхжингийн орны цэцэрлэгт хун, тогос, тоть, хөхөө зэрэг шувууд яруу сайхан хоолойгоор уянгалуулан зогсолтгүй дуулна. Тэд сайн үйл, буян тэргүүтнийг магтан дуулж, Бурхан багшийн сургаалыг номлоно.

Хүмүүс яруу сайхан хоолойгоор уянгалуулан дуулах шувуудыг сонсоод Бурхан багшид сүсэглэн, сургаал юуг нь бясалгаж, энх амгалан, эв найрын төлөө залбиран мөргөнө. Эдгээр дууг сонсч буй хэн боловч Бурхан багшийн дуулал хэмээн болгоож,

Бурхан Багшийн Аврал

Бурхан багшид сүсэглэх нь улам батжиж, шинэ шинэ баяр баясгаланд автаж, бусад ертөнцөд амьдардаг Бурхан багшийн сургаалыг дагагчидтай сайн буяны бүх ерөөлөө улам улам батжуулна.

Ариухан салхи намуухан сэвэлзэж эрдэнэсийн моддыг үл мэдэг ганхуулж, гэрэл гэгээ цацруулсан олон хонхыг хөндөхөд, тэдгээр хонх тус тусдаа нэг нэг эгшиглэнт ая тоглож эхэлнэ.

Хүмүүс түүнийг сонсоод Бурхан багшид залбиран мөргөж, сургаал юуг нь бодон бясалгаж, амар амгалан, эв найртай амьдралын төлөө мөргөн залбирч эхэлнэ. Бурхан багшийн ертөнц ийм бодь чанар, урьд өмнө үзэгдээгүй гоо үзэсгэлэнгээр дүүрэн юм.

3. Яагаад энэ ертөнцийн Бурхан багшийг зах хязгааргүй гэрэл гэгээ, эцэс төгсгөлгүй амьдралын Бурхан багш хэмээн алдаршуулна вэ? Учир нь Бурхан багшийн гэрэл гэгээг хэмжиж үл болно. Тэрбээр хорвоогийн арван зүгийн бүх орныг гийгүүлэн буй ч, гэрэл гэгээ нь шавхагдаж үл дуусна. Түүний амьдрал эцэс төгсгөлгүй. Тиймээс Түүнийг ийнхүү нэрлэн алдаршуулдаг.

Энэхүү ертөнцөд мэндэлсэн бүхэн эргээд төөрөгдлийн ертөнцөд үл очно. Тэднийг ч гэсэн тоолж баршгүй.

Бурхан багшийн гэгээ гэрлээр гийсэн мөн адил тоо томшгүй олон хүн шинэ амьдралд сэргж мэндэлдэг.

Хэрэв хүн ертөнцөөс одох цаг ирэхэд Бурхан багшийн нэр алдрыг бүтэн нэг өдөр юм уу, эсвэл долоо хоногийн турш дуудан алдаршуулвал Бурхан багш олон ариун явдалтнаа дагуулан түүний өмнө тодорно. Тийм хүний сүнс заавал Бурхан багшийн ертөнцөд мэндэлнэ.

Хэрэв хүн Бурхан багшийг таньж мэдээд Түүний сургаалд итгэн сүсэглэвээс л тэрбээр Бурхан багш нарын ивээл дор, оройн дээд гэгээрэлд хүрнэ.

